# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 10 (391)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай*
- *Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *"Монгол төрийн үндэсний хөгжмийн их найрал" байгуулах тухай*
- *Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлд нэмэлт оруулах тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2005 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2005 оны гуравдугаар сарын 14 №10 (391)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | | |
|---|---|---|---|
| 610. | Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай | | 170 |
| 611. | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай | | 170 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|---|---|---|---|
| 612. | Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 17 | 170 |
| 613. | Нацагийн Бямбадоржийг "Шударга журам" медалиар шагнах тухай | Дугаар 18 | 175 |
| 614. | "Монгол төрийн үндэсний хөгжмийн их найрал" байгуулах тухай | Дугаар 20 | 175 |
| 615. | Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлд нэмэлт оруулах тухай | Дугаар 21 | 176 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 616. | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай | Дугаар 245 | 176 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 2 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** "Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн ОХУ-аас импортолж байгаа цахилгаан эрчим хүчийг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хууль 2005 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болно.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н. ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 2 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

### ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** "Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн ОХУ-аас импортолж байгаа цахилгаан эрчим хүчийг гаалийн албан татвараас 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хууль 2005 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болно.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н. ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 2 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, эрүүл мэнд, ус, цаг уур, хөдөө аж ахуй, зам, тээвэр, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй, идэвх санаачилгатай ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

#### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Бандийн Гунгаа- Нийслэлийн Баянгол дүүргийн "Оюуны ундраа" цогцолбор сургуулийн биеийн тамирын багш

2. Ядамсүрэнгийн Сэрэвжаа- Монгол Улс, БНХАУлсын хоорондын улсын хилийг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн геодезийн мэргэжилтэн

3. Равдангийн Хатанбаатар- Монгол Улс, БНХАУлсын хоорондын улсын хилийг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн дарга, тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд

4. Бадамын Хишигтогтох- Нийслэлийн хүнсний үйлдвэрлэлийн "АПУ" ХК-ийн архины үйлдвэрийн технологич

5. Шижээгийн Хэнмэдэх- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын ахлах референт

#### ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Мөнхийн Ганболд-Монгол Улс, БНХАУлсын хоорондын улсын хилийг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн хилийн мэргэжилтэн, хурандаа

2. Лувсаншаравын Цэдэн- Хил хамгаалах ерөнхий газрын хүний нөөцийн хэлтсийн дарга, хурандаа

3. Сүхийн Цэрэннамжил- Хилийн 0146 дугаар ангийн хилийн албаны дарга, дэд хурандаа

**АЛТАН ГАДАС ОДОНГООР:**

1. Мялын Агваанзундуй- Хэнтий аймгийн Галшар сумын малчин

2. Пэлжидийн Алтангэрэл- Нийслэлийн Евро-Ази дээд сургуулийн сургалт эрхэлсэн дэд захирал

3. Бумбадайн Амаржаргал- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 жилийн 41 дүгээр сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

4. Сандуйжавын Амарсайхан- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10 жилийн 1 дүгээр сургуулийн түүхийн багш

5. Галсандоржийн Баасанхүү- Ус цаг уур , орчны шинжилгээний газрын ус, цаг уурын хүрээлэнгийн технологич инженер

6. Сэвжидийн Бадамжав- Улсын Клиникийн нэгдсэн 2 дугаар эмнэлгийн захирал

7. Цогтын Батбаяр- Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг дарга

8. Паалайн Батхүү- ЭМШУИС-ийн хүүхдийн анагаах тэнхмийн багш

9. Жамсрангийн Баянмөнх- Говьсүмбэр аймгийн Засаг дарга

10. Жадамбын Баярмаа - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 жилийн 7 дугаар сургуулийн монгол хэл,уран зохиолын багш

11. Гомбын Баярцэнгэл- Өмнөговь аймгийн "Даланзадгадын дулааны цахилгаан станц" ХК-ийн засварчин

12. Пүрэвийн Борхүү- Нийслэлийн Налайх дүүргийн "Чандмань" цогцолбор сургуулийн газарзүйн багш

13. Цэрэнжавын Борчулуун- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч

14. Жамъянгийн Бүрнээ- Хэнтий аймгийн Батноров сумын малчин

15. Пүрэвийн Бямбаа- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Монгол экспорт" ХХК-ийн туслах аж ахуйн ногоочин

16. Ринчингийн Ганбат- Нийслэлийн чөлөөт хэвлэл "Орчин цаг" сонины эрхлэгч

17. Дамбын Ганбаяр- "Хурд" хамтлагийн ахлагч

18. Санжкавын Ганболд- Нийслэлийн нийтийн тээврийн "Авто тээврийн тав" ХК-ийн ерөнхий захирал

19. Энэбишийн Ганболд- ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн ургамал судлагч

20. Найдангийн Ганхуяг- СУИС-ийн тэнхмийн эрхлэгч

21. Банзрагчийн Ганхүү- Нийслэлийн хүнсний үйлдвэрлэлийн "АПУ" ХК-ийн засварчин

22. Загдын Гончигжав- Орхон аймгийн Баян-Өндөр сумын зурхай судлаач, ламтан

23. Бэгзжавын Гүнрэгмаа- Завхан аймгийн орон нутгийг судлах музейн сан хөмрөгч

24. Ширнэнгийн Даваасүрэн- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 10 жилийн 76 дугаар сургуулийн бага ангийн багш

25. Ичинхорлоогийн Дагвадорж- ХАА, Хүнс, Байгаль орчны Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны ахмадын зөвлөлийн дарга

26. Баянгийн Дампил- ХААИС-ийн Инженерийн сургуулийн багш

27. Пунцагийн Дамчаабазар- Ховд аймгийн Дарви сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч

28. Аюушийн Дондов- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 10 жилийн 42 дугаар сургуулийн математикийн багш

29. Дарамбазарын Доржцэнд- Нийслэлийн Захирагчийн ажлын албаны үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн

30. Жагваралын Дорлигсүрэн- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 10 жилийн 37 дугаар сургуулийн сургалтын менежер

31. Чойжилын Дулам- Нийслэлийн хүнсний үйлдвэрлэлийн "Жүр үр" ХХК-ийн гүйцэтгэх захирал

32. Гоожавын Жигмэд- "Улаанбаатар зам засвар" компанийн эдийн засагч

33. Лувсангомбын Лхагвадорж- Нийслэлийн геодези, зурагзүйн "Аэрогеодези" ХК-ийн ахлах техникч

34. Баасандоржийн Лувсандорж- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10 жилийн 1 дүгээр сургуулийн биеийн тамирын багш

35. Дагвадоржийн Магсар- ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн секторын эрхлэгч

36. Бүдрагчаагийн Монхоо- Монгол Улсын Ерөнхийлөгчийн шадар туслах

37. Моломын Моонон- Нийслэлийн Налайх дүүргийн "Голомт" цогцолбор сургуулийн шугам зургийн багш

38. Тогтохын Мөнхбат- Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын орлогч, ерөнхий мал зүйч

39. Балдандамбын Намхайжанцан- Монгол Улсын Ерөнхийлөгчийн эдийн засгийн бодлогын зөвлөх

40. Загдсүрэнгийн Нэргүй- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 жилийн 60 дугаар сургуулийн бага ангийн багш

41. Базаррагчаагийн Нямхүү- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч

42. Шаравдоржийн Очирсүх- Дорноговь аймгийн Сайншанд сумын худалдаа, үйлчилгээний "Их-Уулын говь" ХХК-ийн захирал

43. Чимэдийн Оюунбаатар - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Тохижилт үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга

44. Чойжинжавын Оюунцэцэг-Монголын радиогийн ахмад ажилтан

45. Балжиннямын Пүрэв- Дорноговь аймгийн Сайншанд сум дахь УБТЗ-ын эрчим хүч усан хангамжийн хоёрдугаар ангийн харьяа цахилгаан шугам сүлжээний хэсгийн худгийн машинч

46. Чагнаагийн Пүрэвдорж- МУБИС-ийн боловсролын удирдахуйн ухааны тэнхмийн эрхлэгч

47. Нянрагийн Пүрэвжав- ЭМШУИС-ийн нүүр амны согог, гажиг заслын тэнхмийн эрхлэгч

48. Луваанжавын Рэгзэдмаа- Нийслэлийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн өмгөөлөгч

49. Даваадагвын Сайнбилэг- Нийслэлийн Өмчийн харилцааны газрын менежер

50. Бандзайн Сайнжаргал- МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн нягтлан бодох бүртгэлийн тэнхмийн эрхлэгч

51. Гомбоцэрэнгийн Сампил- Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын малчин

52. Самбуугийн Содном- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 жилийн 18 дугаар сургуулийн түүхийн багш

53. Түмэнбаярын Содномдаргиа- Нийслэлийн "Тэнгэр" дээд сургуулийн захирал

54. Дагвасамбуугийн Сономдорж -Баянхонгор аймгийн тээвэр зохицуулалтын газрын жолооч

55. Бадарчийн Сүрэнхорлоо- ХҮДС-ийн мэргэжлийн сургалтын төвийн эрхлэгч

56. Дамбадаржаагийн Сүхбаатар-Нийслэлийн Баянгол дүүргийн 10 жилийн 28 дугаар сургуулийн захирал

57. Гончигшаравын Сүхэнбаатар-Нийслэлийн Баянгол дүүргийн "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн захирал

58. Агваан-Осорын Сэмжид- Нийслэлийн худалдаа үйлчилгээний "Алтжин" ХХК-ийн нефть хариуцсан дэд захирал

59. Цагааны Сэндэндулам- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 жилийн 7 дугаар сургуулийн бага ангийн багш

60. Ендонгийн Тайван- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 жилийн 60 дугаар сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

61. Базаргочоогийн Төмөрсанаа- Нийслэлийн барилга үйлдвэрлэлийн "Сан-Энерго-Строй трейд" ХХК-ийн бригадын дарга

62. Долгорын Тунгалаг- Сэлэнгэ аймгийн Мандал сумын 10 жилийн 3 дугаар сургуулийн захирал

63. Пилээгийн Түвшээ- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 жилийн 7 дугаар сургуулийн сургалтын менежер

64. Уртнасангийн Уранчимэг- Улсын драмын эрдмийн театрын жүжигчин

65. Чимиддоржийн Уранчимэг- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10 жилийн 58 дугаар сургуулийн нийгмийн ажилтан

66. Охидойн Хишигтогтох- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 жилийн 41 дүгээр сургуулийн бага ангийн багш

67. Сэндэнхүүгийн Хоролсүрэн- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 жилийн 60 дугаар сургуулийн бага ангийн багш

68. Лодонгийн Хулганаа- Санхүү эдийн засгийн дээд сургуулийн үйлчлэгч

69. Аръядамбын Хүрэлбаатар- Нийслэлийн геодези, зурагзүйн "Аэрогеодези" ХК-ийн товчооны дарга

70. Дүйнхүрэлдэйн Хээнээ- Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний "Ач буян трэвел" ХХК-ийн жолооч

71. Дамдины Цоодол- Говь-Алтай аймгийн худалдаа, үйлчилгээний "Их овоо трейд" ХХК-ийн ерөнхий захирал

72. Цогийн Цэгмэд- ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

73. Дамдинхүүгийн Цэдэндорж- Нийслэлийн геодези, зураг зүйн "Аэрогеодези" ХК-ийн захирал

74. Онгойн Цэнд- Өвөрхангай аймгийн нийтийн аж ахуйн "Мон мандал" ХХК-ийн үсчний дамжааны багш

75. Хаг-Очирын Цэндсүрэн- Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Эрдэнэт" цогцолбор сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

76. Лундэнбазарын Цэрэнжав- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 10 жилийн 39 дүгээр сургуулийн сургалтын менежер

77. Бадарчийн Цэсүрэн- Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Эрдэнэт" цогцолбор сургуулийн физикийн багш

78. Шагдардагвын Цэсүрэн- Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 10 жилийн нэгдүгээр сургуулийн математикийн багш

79. Далхын Чанцал- Нийслэлийн Баянгол дүүргийн 10 жилийн 47 дугаар сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

80. Чулууны Чинбат- Хөгжим бүжгийн коллежийн зөвлөх багш

81. Ажиндайн Чойжамц- ХААИС-ийн тариалангийн технологийн тэнхимийн багш

82. Доржийн Энэбиш- Нийслэлийн худалдаа үйлчилгээний "Гурван эвтэн" ХХК-ийн харъяа "Меркури" төвийн захирал

83. Туваaны Янжин- Дархан-Уул аймгийн Дархан сумын 22 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

**ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:**

1. Пүрэвийн Бямбаа - Хилийн 0166 дугаар ангийн хилийн албаны офицер, дэд хурандаа

2. Дамдины Гантөмөр- Хилийн 0198 дугаар ангийн захирагч, хурандаа

3. Бүрхэдбайн Сейлхан- Баян-Өлгий аймгийн Өлгий сумын өндөр настан, ахмад цаг уурч

**ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Должингийн Алтангарьд- УБТЗ-ын дохиолол холбооны Дорноговь аймгийн Замын-Үүд дэх цахилгаан шугам сүлжээний хэсгийн ахлах цахилгаанчин

2. Дагважанцангийн Алтанцэцэг- Нийслэлийн Татварын газрын татварын улсын байцаагч

3. Бат-Очирын Аня- Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Эрдэнэт" цогцолбор сургуулийн бага ангийн багш

4. Далайн Баасан- Монгол Улс, БНХАУлсын хоорондын улсын хилийг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн санхүү, захиргааны ажил эрхэлсэн дэд дарга

5. Түдэвдоржийн Баасанжав- Дорноговь аймгийн Сайншанд сум дахь УБТЗ-ын эрчим хүч усан хангамжийн хоёрдугаар ангийн харъяа цахилгаан шугам сүлжээний хэсгийн дарга

6. Гунгаагийн Багаа- Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн 88 дугаар сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

7. Зоригтын Байгалмаа- Нийслэлийн Баянгол дүүргийн "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн сургалтын менежер

8. Цэвэгмэдийн Батгэрэл- Нийслэлийн Баянгол дүүргийн 10 жилийн 47 дугаар сургуулийн захирал

9. Өлзийтогтохын Батмөнх- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Алтжин" ХХК-ийн САПУ үйлдвэрийн дарга

10. Пэрэнлэйн Болдбаатар- Газрын харилцаа, геодези, зурагзүйн газрын геодезийн хэлтсийн дарга

11. Рэнцэндоржийн Бумдарь- МонЦаМэ агентлагийн Сэлэнгэ аймаг дахь сурвалжлагч

12. Цэрэндэжидийн Будээдагина- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор нэгдүгээр сургуулийн хөдөлмөрийн багш

13. Дондовын Бямбасүрэн- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10 жилийн 58 дугаар сургуулийн бага ангийн багш

14. Жигжидийн Ганбат- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 10 жилийн 39 дүгээр сургуулийн захирал

15. Энэбишийн Гоожидмаа- Төв аймгийн Борнуур сумын 10 жилийн сургуулийн сургалтын менежер

16. Гарьдын Даваахүү- Нийслэлийн орос хэлний "Галакси" сургууль, цэцэрлэгийн цогцолборын ерөнхий захирал

17. Жалцавын Дамдинсүрэн- Нийслэлийн геодези, зурагзүйн "Аэрогеодези" ХК-ийн ахлах техникч

18. Пүрэвийн Дугарсүрэн- Төв аймгийн Эрдэнэ сумын Мэргэжлийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн дадлагын багш

19. Лувсанцэрэнгийн Дэлгэрбат- Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал

20. Чулуунбаатарын Дэмчигсүрэн- Завхан аймгийн Нэгдсэн эмнэлгийн гэмтэл, согогийн их эмч

21. Доржийн Жавзмаа- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 жилийн 60 дугаар сургуулийн бага ангийн багш

22. Багварын Жаргал- Өмнөговь аймгийн Ноён сумын сум дундын эмнэлгийн хүүхдийн их эмч

23. Даваасамбуугийн Ившин- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор нэгдүгээр сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

24. Нанжидын Мөнгөнцэцэг- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 53 дугаар цэцэрлэгийн багш

25. Баньдхүүгийн Мөнхзул- Нийслэлийн геодези, зурагзүйн "Аэрогеодези" ХК-ийн товчооны дарга

26. Өлзийбатын Мөнхтуяа- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Алтжин" ХХК-ийн хуулийн зөвлөх

27. Готовын Мядагмаа - Нийслэлийн хүнсний үйлдвэрлэлийн "Талх чихэр" ХК-ийн үйлчилгээ, аж ахуйн мастер

28. Бямбажавын Нина- Нийслэлийн Баянгол дүүргийн "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн бага ангийн багш

29. Санжаасүрэнгийн Оюун - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн 88 дугаар сургуулийн бага ангийн багш

30. Лувсандоржийн Оюунбилэг- СУИС-ийн харьяа Соёлын коллежийн салбарын эрхлэгч

31. Нэргүйн Оюунгэрэл- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээний компанийн нярав

32. Гомбын Өлзийхутаг- Хэнтий аймгийн Хэрлэн сумын 3 дугаар сургуулийн математикийн багш

33. Баярчулууны Сарантуяа- Сэлэнгэ аймгийн орон нутгийг судлах музейн ажилтан

34. Санжаажамцын Тунгалаг- Нийслэлийн Баянгол дүүргийн "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн сургалтын менежер

35. Чоймболын Тэгш-Амгалан- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор нэгдүгээр сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

36. Уюйгийн Уртнасан- Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Эрдэнэт" цогцолбор сургуулийн зохион бүтээх хөдөлмөрийн багш

37. Нямдагийн Хандармаа- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Алтжин" ХХК-ийн нягтлан бодогч

38. Довдонгийн Хишигхорол- Нийслэлийн геодези, зурагзүйн "Аэрогеодези" ХК-ийн инженер

39. Дагвын Хүрэлбаатар- УБТЗ-ын Дорноговь аймгийн Замын-Үүд өртөөний дарга

40. Лувсандоржийн Цогзолмаа- Төв аймгийн Батсүмбэр сумын дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

41. Гонгордоржийн Цэрэнлхам- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 10 жилийн 37 дугаар сургуулийн бага ангийн багш

42. Цэвгээгийн Цэцэгмаа- ХААИС-ийн ерөнхий санхүүч

43. Цэвэгдоржийн Цэцэгмаа- Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Эрдэнэт" цогцолбор сургуулийн сургалтын менежер

44. Чойдорын Чулуунбаатар- Хэнтий аймгийн Хэрлэн сумын 4 дүгээр сургуулийн физикийн багш

45. Гомбожавын Чулуунхүү- Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн 88 дугаар сургуулийн цахилгаанчин

46. Тувшинбаярын Чулуунцэцэг- Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн нягтлан бодогч

47. Аюушийн Шүрэнцэцэг-Сэлэнгэ аймгийн Сант сум дахь Мэргэжлийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн багш

48. Дэмбэрэлийн Энхжаргал- Завхан аймгийн Улиастай сумын "Чандмань-Эрдэнэ" цогцолбор сургуулийн хичээлийн эрхлэгч

49. Бяруузаны Эрдэнэбаатар- Нийслэлийн геодези, зурагзүйн "Аэрогеодези" ХК-ийн ерөнхий инженер

50. Цамбажавын Эрдэнэбаяр- Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч

51. Лувсангийн Эрдэнэдалай-Монголын Цахилгаан холбоо компанийн нягтлан бодогч

52. Аюурзанын Эрдэнэтуяа- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн дарга

53. Сэндэнгийн Янжмаа- Төв аймгийн Борнуур сумын 10 жилийн сургуулийн бага ангийн багш

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Лхаасүрэнгийн Баатар- Хилийн 0132 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч

2. Норовын Баатархуяг- Хилийн 0146 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч

3. Раашийн Баярмагнай - Хилийн 0253 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч

4. Адайханы Бүркит- Хилийн 0165 дугаар ангийн хилийн албаны ахлах офицер, хошууч

5. Хожгорын Лхагвасүрэн- Хилийн 0165 дугаар ангийн захирагч, хурандаа

6. Чоёндаваагийн Сайнтөр - Хилийн 0168 дугаар ангийн захирагч, хурандаа

7. Гончигийн Төрбат - Тагнуулын ерөнхий газрын Төрийн ордны хамгаалалтын албаны ажилтан, ахлах ахлагч

8. Довжидийн Энхбат - Хил хамгаалах ерөнхий газрын хэлтсийн дарга, дэд хурандаа

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 2 дугаар сарын 04-ний өдөр** **Дугаар 18** **Улаанбаатар хот**

**Нацагийн Бямбадоржийг "Шударга журам" медалиар шагнах тухай**

Эр зориг, авхаалж самбаа гарган усны аюулаас хүний амь аварч иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Ховд аймгийн Алтай сумын Бодонч багийн иргэн Нацагийн Бямбадоржийг "Шударга журам" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 2 дугаар сарын 16-ны өдөр** **Дугаар 20** **Улаанбаатар хот**

**"Монгол төрийн үндэсний хөгжмийн их найрал" байгуулах тухай**

Хүн улсын үеэс Монгол гүрний тусгаар тогтнолыг илтгэн, төрийн сүр хүчийг бадраан, дээдсийн онгон шүтээнийг урин дуудаж, түмэн олны сүлд хийморийг сэргээн, үе дамжин уламжилсан монгол төр ёсны хөгжмийн урлагийн өнө эртний гайхамшигт өвийг Монголын ээнт гүрэнд өвлүүлэн,

төрийн их найрал хөгжмийн өлмийг батжуулсан Чингис хааныхаа төр ёс, түүхэн уламжлалыг сэргээх тухайд эрдэмтэн мэргэд, урлаг соёлын зүтгэлтэн, мэргэжлийн урлагийн байгууллагуудаас гаргаж буй саналыг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь заалтыг тус тус баримтлан ЗАРЛИГ буулгах нь:

1. Монгол үндэсний найрал хөгжмийн бүтэц, бүрэлдэхүүн, хөгжимчдийн эгнээг өргөжүүлэн "Монгол төрийн үндэсний хөгжмийн их найрал" байгуулан Үндэсний их баяр наадам, нийтээр тэмдэглэх баярын төрийн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ, төрийн үндэсний, дипломат ёслолын үеэр эгшиглүүлж хэвшүүлсүгэй.

2. "Монгол төрийн үндэсний хөгжмийн их найрал"-ын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, хөгжмийн зэмсгийн төрөл, ангиллыг өргөтгөх, төрийн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээний үеэр эгшиглэх хөгжмийн бүтээлүүд туурвих, хөгжимчдийн хувцас бэлтгэх зэрэг цогц асуудлыг тусгасан хөтөлбөр боловсруулж, Төрийн ёслолын журамд нэмэлт өөрчлөлт оруулж мөрдөхийг Засгийн газарт чиглэл болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ

Арван долоодугаар жарны "Газар тэтгэгч" хэмээх модон тахиа жилийн хаврын тэргүүн сарын шинийн найман.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 2 дугаар сарын 23-ны өдөр** **Дугаар 21** **Улаанбаатар хот**

**Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлд нэмэлт оруулах тухай**

Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлд нэмэлт оруулахын тулд ЗАРЛИГ болгох нь:

Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1998 оны 29 дүгээр зарлигийн хавсралтын "Албан тушаалын ангилал" гэсэн хэсэгт "11.Хил хамгаалах ерөнхий газрын дэд дарга бөгөөд Хилийн цэргийн штабын дарга", "Цэргийн цолны зэрэглэл" гэсэн хэсэгт "хурандаа-хошууч генерал" гэж нэмэлт оруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 12 дугаар сарын 22-ны өдөр** **Дугаар 245** **Улаанбаатар хот**

**Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай**

"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын 2004 оны 24 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган Засгийн газарт мэдээлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц. ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД Ч. УЛААН

*Засгийн газрын 2004 оны 245 дугаар тогтоолын хавсралт*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | | Зорилт | Арга хэмжээ | Хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|---|
| | | | **Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГА, ИРГЭНИЙ ОРОЛЦОО** | | |
| | | | **1.1. Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, иргэдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр Засгийн газрын түвшинд баталж мөрдөх эрх зүйн баримт бичгүүд, стандартын шаардлагуудыг шинэчлэн, төрийн үйлчилгээг үр дүнтэй хүртээмжтэй болгохыг зорино. Энэ зорилтын хүрээнд:** | | |
| 1 | 1.1.1 | Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах явцыг нээлттэй болгож, дээрх асуудлыг аль болох ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа тал болон иргэдийн санаа бодолд тулгуурлаж шийддэг жишиг тогтооно. | 1. Шийдвэр гаргах явцыг нээлттэй байлгах асуудлыг хуульчлан баталгаажуулж, эрх ашиг нь хөндөгдөж байгаа иргэд, байгууллагаас саналыг нь авах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авна. | 2005 | Ц.Нямдорж<br>С.Баярцогт |
| | | | 2. Засгийн газрын худалдан авах ажиллагаанд хувийн хэвшил, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, тэдгээрийн зүгээс хяналт тавих чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, арга зүйн зөвлөгөөг үргэлжлүүлнэ. | 2005- 2008 | Н.Алтанхуяг |
| | | | 3. Хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон бусад актын төслийг боловсруулах явцад цахим хэлбэрээр иргэд, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдээс санал авах талаар журам боловсруулж мөрдүүлнэ. | 2005-2006 | Ц.Нямдорж,<br>С.Баярцогт |
| | | | 4. "Цахим Засгийн газрын нэгдсэн вэб сайт" төсөл хэрэгжүүлнэ. | 2005 оноос | С.Баярцогт |
| 2 | 1.1.2 | Төрийн албан хаагчдаас иргэдэд үйлчлэх эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ мөрдөх албаны болон ёс зүйн журмыг гаргаж, түүнийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэн олон нийтийн хяналтын дор хэрэгжүүлнэ. | 1. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ. | 2005 | С.Баярцогт<br>Ж.Норовсамбуу |
| | | | 2. Төрийн тусгай албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрэм, түүнийг сахиулах механизмын байдалд судалгаа, дүгнэлт хийж, туршлагыг нийтийн хүртээл болгоно. | 2005-2006 | С.Баярцогт<br>Ж.Норовсамбуу |
| | | | 3. Төрийн албан хаагчдаас иргэдэд үйлчлэхдээ мөрдөх албаны болон ёс зүйн хэм хэмжээг ажлын байрны тодорхойлолтод тусгаж байгууллага бүрийн вэб хуудсанд нээлттэй тавьж ил тод байлгана. | 2004-2005 | С.Баярцогт<br>Сайд нар |
| | | | 4. Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ. | 2005 оноос | С.Баярцогт<br>Ц.Нямдорж |
| 3 | 1.1.3 | Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагчийн ёс зүй, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах, хариуцлага хүлээлгэх зарчмыг тодотгосон өөрчлөлт оруулна. | 1. Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулна. | 2006 | С.Баярцогт<br>Ц.Нямдорж |
| | | | 2. Төрийн байгууллагад олон улсын тогтолцоо (ISO 9000)-г нэвтрүүлэх талаар хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, шат дараалсан арга хэмжээ авна. | 2005-2008 | С.Баярцогт<br>Сайд нар |
| | | | 3. Төрийн бүх шатны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ хэрэглэгчдийн саналыг харгалзан үздэг болно. | 2005 оноос | С.Баярцогт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | 1.1.4 | Төрийн алба, үйлчилгээнд түвшин тогтоож, түүнийг гүйцэтгэх, хэрэгжүүлэх үйл ажиллагаагаар иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагад улам нээлттэй болгоно. | 1. Төрийн үйлчилгээний төрлүүдээр стандарт бий болгож, мөрдүүлэх арга хэмжээ авна. | 2005-2007 | С.Баярцогт<br>Сайд нар |
| | | | 2. Төрийн байгууллагын үйл ажиллагаа (байгууллагын нээлттэй байдал, хариуцлагын түвшин, хуулийн хэрэгжилтийн байдал, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн байдал)-нд түвшин тогтоож, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэдэд мэдээлдэг болно. | 2005 | С.Баярцогт |
| | | | 3. Төрийн алба, үйлчилгээний түвшингийн гүйцэтгэлийн талаар хэрэглэгчийн дунд санал асуулга явуулах нэгдсэн арга зүйг хандивлагч орон, олон улсын байгууллагатай хамтран боловсруулна. | 2005 | С.Баярцогт<br>Ж.Норовсамбуу |
| | | | 4. Төрийн бус байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний жагсаалт, журмыг баталж мөрдүүлнэ. | 2005-2008 | С.Баярцогт |
| | | | 5. Төрийн үйлчилгээний албанд хамаарах албан хаагчдын хүрээг багасгаж, улмаар төрийн байгууллагын эрхэлж байгаа зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх явдлыг ажил хэрэг болгоно. | 2005–2008 | С.Баярцогт<br>Ц. Баярсайхан |
| 5 | 1.1.5 | Төрийн төв болон орон нутгийн байгууллагын үүрэг, үйл ажиллагааны хүрээг тодотгож, хүрсэн үр дүнд тулгуурлан эрх үүргийн шилжилтийг нарийвчлан тогтооно. | 1. Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн шинжилгээг Төрийн албаны зөвлөл, Сангийн яамны оролцоотойгоор дотоод, гадаадын экспертүүдтэй хамтран гүйцэтгэж, тэдгээрийн чиг үүргийг боловсронгуй болгох санал боловсруулан шийдвэрлүүлэх ажлыг дэс дараатайгаар хэрэгжүүлнэ. | 2005-2007 | С.Баярцогт<br>Ж.Норовсамбуу |
| 6 | 1.1.6 | Төрийн байгууллага бүрийн эрхэмлэх зорилго, шийдвэрлэх асуудал, түүнд тавигдах шаардлага зэргийг нийтэд ил тод байлгана | 1. Төрийн захиргааны төв байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинээр болон шинэчлэн боловсруулан мөрдүүлж, нийтэд ил тод болгон Засгийн газрын вэб хуудсанд тавина. | 2005 | С.Баярцогт |
| 7 | 1.1.7 | Нийгмийн бүх салбарт хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлын стандартыг хангах, түүнийг баталгаажуулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ. | 1. Олон нийтийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаар хангах, хэрэглэгчдийн эрхийг хамгаалахад чиглэсэн гадаад орнуудын стандарт, дүрэм, журмыг судалж, хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хангах зорилгоор бүх салбарт үндэсний стандартыг олон улсын жишигт хүргэх чиглэл боловсруулах ажлыг зохион байгуулна. | 2005-2008 | Ч.Улаан<br>Сайд нар |
| | | | 2. Агаарын бохирдол, ус, эм, хүнсний стандартыг хүний аюулгүй байдалд нийцүүлэн шинэчилнэ. | 2006 | У.Барсболд<br>Т.Ганди<br>Д.Тэрбишдагва |
| 8 | 1.1.8 | Иргэдийн хувийн нууц, өмч хөрөнгө, орон байрны халдашгүй дархан байдлыг хуулиар баталгаажуулна | 1. Иргэдийн хувийн нууц, өмч хөрөнгө, орон байрны халдашгүй дархан байдлын баталгаажуулахтай холбогдуулан нууцын тухай багц хууль, банкны тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг судлан боловсруулна. | 2006 | Ц.Нямдорж<br>Н.Алтанхуяг<br>С.Баярцогт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2. Бизнесийн болон худалдааны нууц, бизнесийн зах зээлийн судалгааны нууцлалыг хангах, өмчийн барьцааг хамгаалах эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран санал боловсруулна. | 2005-2008 | С.Батболд<br>Ц.Нямдорж |
| 9 | 1.1.9 | Хуулиар зөвшөөрөгдсөн аливаа мэдээлэлтэй танилцах, мэдээлэл гаргуулан авах хүсэлт тавих, түүнийгээ хэрэгжүүлэх эрхээр иргэдийг хангана. | 1. Хуулиар зөвшөөрөгдсөн аливаа мэдээллийг иргэдэд нээлттэй байлгах, хяналт шалгалтын ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. | 2004-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 2. Засгийн газрын нээлттэй хурлын шийдвэр, олон нийтэд нээлттэй бусад баримт бичгийг иргэдийн хүсэлтээр, зардлыг нь шингээсэн үнээр хувилан хүргэх үйлчилгээг бий болгон хэвшүүлнэ. | 2005 | С.Баярцогт |
| | | | 3. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг Сангийн яамны вэб хуудсанд байрлуулж, төсвийн ил тод байдлыг хангах замаар хуульд заасан хүрээнд ард иргэдэд чөлөөтэй үйлчлэх боломжийг бүрдүүлнэ. | 2005-2008 | Н.Алтанхуяг |
| 10 | 1.1.10 | Үндэсний радио, телевиз болон төрийн өмчийн бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслийг төрийн мэдлээс гаргаж, бие даасан байдлыг нь хангана | 1. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн төслийг боловсруулж, хэвлэл мэдээллийн холбогдолтой хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлыг судлан шийдвэрлэнэ. | 2005-2008 | Ц.Нямдорж,<br>С.Баярцогт |
| 11 | 1.1.11 | Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлж, ерөнхий менежерийн чадавхийг хөгжүүлэх зорилтыг салбаруудын стандартын шинэ шаардлагыг гаргаж мөрдүүлэхтэй шууд холбоотойгоор хэрэгжүүлнэ. | 1. Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж баталж мөрдүүлнэ. | 2005-2008 | С.Баярцогт<br>Ж.Норовсамбуу |
| | | | 2. Салбарын хэмжээний эрх зүй, стандарт боловсруулах чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн яам, агентлагийн хууль эрх зүйн албаны ажилтны зорилтот сургалтыг зохион байгуулна. | 2005 | С.Баярцогт<br>Ц.Нямдорж |
| 12 | 1.1.12 | Төрийн бүх шатны албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах ажлыг үргэлжлүүлнэ | 1. Салбарын төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Сайд нар |
| | | | 2. Төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратегитэй уялдуулан нийт төрийн албаны сургалтын хэрэгцээнд дүн шинжилгээ хийж, төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтын бодлого, стратегийг сургалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд тусган төрийн албан хаагчдын урт, богино хугацааны сургалтыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулна. | 2005-2008 | С.Баярцогт<br>Ж.Норовсамбуу |
| 13 | 1.1.13 | Төр, нийгмийн бүх салбарт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлж, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг арилгана. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчдэг соёлыг хэвшүүлнэ. | 1. Жендерийн тэгш байдлын тухай үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2005-2006 | Ц.Баярсайхан |
| | | | 2. Ажлын байранд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж байгаа болон эрх нь зөрчигдөж байгаа байдалд судалгаа хийж, түүнийг таслан зогсоох арга хэлбэрийг судлан хэрэгжүүлж эхэлнэ. | 2005-2008 | Ц.Баярсайхан<br>И.Эрдэнэбаатар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 14 | 1.1.14 | Төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгаж, бүх төрлийн зөвшөөрөл, лицензийг олгодог журмыг хялбарчлан төрөөс иргэдэд бизнес эрхлэхэд нь ижил тэгш нөхцөл олгоно. | 1. Аж ахуйн нэгжийг бүртгэх үйл ажиллагааг хялбаршуулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулна. | 2005 | С.Батболд |
| | | | 2. Гаалийн бүрдүүлэлтэд жишиг үнэ тогтоож байгаа өнөөгийн практикийг боловсронгуй болгох асуудлыг судалж шийдвэрлүүлнэ. | 2005-2006 | Н.Алтанхуяг |
| | | | 3. Бизнес эрхлэгчдэд ногдож байгаа хураамжийн ачааллыг багасгах талаар судалгаа хийж санал боловсруулна. | 2005-2008 | С.Батболд |
| | | | 4. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй, газрын харилцаа, хөрөнгийн үнэлгээний ажил, үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог боловсронгуй болгож, ажил үүргийн давхардлыг арилгах замаар шат дамжлагыг эрс цөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 2005 | Н. Батбаяр |
| | | | 5. Төрийн байгууллагаас олгож байгаа зөвшөөрөл, лиценз нь хуульд, тогтоомжид нийцсэн эсэхийг хянан шалгаж, зөвшөөрөл, лиценз олгож байгаа журмыг хялбарчлах замаар төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах арга хэмжээ авна. | 2005-2008 | С.Баярцогт<br>Ц.Нямдорж<br>И.Эрдэнэбаатар |
| 15 | 1.1.15 | "Цахим засаглал" хөтөлбөр хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний хугацаа, хураамжийн хэмжээг оновчтой тогтооно. | 1. "Цахим засаглал" хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын бүртгэл лавламжийн сан болгож лавлагааны нэгжийг нэмэгдүүлнэ. | 2006-2007 | С.Баярцогт |
| | | | 2. Нээлттэй засаглалыг хөгжүүлэх, засаглалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс "Цахим засаглал" хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2006 | С.Баярцогт |
| | | | 3. Төрийн үйлчилгээний үр өгөөж, чанар, хүртээмж, шуурхай байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд төрөөс иргэд, аж ахуй эрхлэгчдэд үзүүлдэг үйлчилгээг үе шаттайгаар онлайн хэлбэрт оруулна. | 2005 оноос | С.Баярцогт |
| | | | 4. Засгийн газрын үйл ажиллагаанд Цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлж Засгийн газрын худалдан авах ажиллагааны талаарх бүх мэдээлэл, тендерийн зар болон үр дүнг тусгай вэб хуудсанд хэвлэн нийтэлдэг журам тогтооно. | 2005 оноос | Н.Алтанхуяг |
| 16 | 1.1.16 | Татвар, гааль, тендер, зайлшгүй байх бүртгэл, зөвшөөрөл болон иргэдийн шилжилт хөдөлгөөнтэй холбогдсон үйлчилгээг сүлжээгээр дамжуулж хийдэг болно. | 1. Засгийн газрын "Цахим Монгол" хөтөлбөртэй уялдуулж, экспорт, импорт, худалдаа үйлчилгээтэй холбоотой лиценз зөвшөөрлийг сүлжээгээр дамжуулан олгох бэлтгэлийг хангана. | 2005-2006 | С.Батболд |
| | | | 2. Электрон-татвар, электрон-гааль, электрон-бичиг хэргийг боловсронгуй болгох замаар бүх системийг хамарсан цаасгүй технологи бүхий үйлчилгээг үе шаттайгаар хэрэгжүүлж, улсын хэмжээний нэгдсэн кодчилолтой болгох арга хэмжээ авна. | 2005 оноос | С.Баярцогт<br>Н.Алтанхуяг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3. Засгийн газрын төсөл, ялангуяа томоохон тендер шалгаруулалтыг хэрэгжүүлэх удирдлагын систем буюу тусгай програм хангамжийг Засгийн газрын байгууллагуудад нэвтрүүлэх замаар захиалагч байгууллагын худалдан авах ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах, бүртгэх, тайлагнахад компьютер, сүлжээ ашиглах чадварыг бий болгоно. | 2006-2008 | Н.Алтанхуяг |
| | | | 4. Бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч, нийлүүлэгч, зөвлөхийн бүртгэл, ангиллын төвлөрсөн мэдээллийн системийг төрийн захиргааны төв байгууллагуудад нэвтрүүлнэ. | 2006-2008 | Н.Алтанхуяг<br>Сайд нар |
| | | | 5. Зохих бэлтгэл хангасны үндсэн дээр татварын албадад аж ахуйн нэгж байгууллагаас татварын тайланг электрон шуудангаар авах, зөвлөгөө, лавлагааг электрон шуудан, веб хуудсаар өгөх ажлыг судлан хэрэгжүүлнэ. | 2006-2008 | Н.Алтанхуяг |
| | | | 6. Татвар, гаалийн албадын хоорондох мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудлыг судлан шийдвэрлэнэ. | 2006-2007 | Н.Алтанхуяг |
| 17 | 1.1.17 | Төрийн албаны үйлчилгээг хялбаршуулж, цахим программд шилжүүлснээр төрийн албанд цаас хэрэглэх явдлыг багасгах, халах арга хэмжээг авна. | 1. Төрийн байгууллагууд дотооддоо интранет байгуулж, түүн дээр суурилсан дотоод үйл ажиллагаа, бичиг хэрэг хөтлөлтийг онлайн болгох замаар цаас хэрэглэх явдлыг багасгана. | 2005 оноос | С.Баярцогт<br>Сайд нар |
| | | | 2. Төрийн бүх байгууллагууд үндэсний нэгдсэн сүлжээнд холбогдож мэдээлэл солилцох үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2006 оноос | С.Баярцогт |
| | | | 3. Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгоно. | 2005-2006 | Н.Алтанхуяг |
| 18 | 1.1.18 | Төрийн захиргааны байгууллагын аппаратыг чадварлаг болгох замаар албан хаагчдын цалинг өсгөж, үүрэг, хариуцлагыг нь нэмэгдүүлнэ. | 1. Төрийн байгууллагуудын зардлыг бууруулах, хөдөлмөрийн хөлсийг ажлын үр дүнтэй холбох замаар албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх боломжийг бий болгоно. | 2005-2008 | С.Баярцогт<br>Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг |
| | | | 2. Төрийн захиргаа, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн боловсруулж, баталж мөрдүүлнэ. | 2005-2006 | С.Баярцогт<br>Ц.Баярсайхан<br>Ж.Норовсамбуу |
| | | | 3. Төрийн албан хаагчдын цалин хөлс, гүйцэтгэлийн бонусын шинэ тогтолцоог боловсруулж хэрэгжүүлнэ. | 2006-2008 | С.Баярцогт<br>Ц.Баярсайхан<br>Ж.Норовсамбуу |
| 19 | 1.1.19 | Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийг боловсронгуй болгон, бусоо удирдлагын санхүү, эрх зүйн орчинг бүрдүүлэн, аливаа хяналт шалгалтыг зөвхөн хуулийн хүрээнд явуулж хэвшүүлнэ. | 1. Мэргэжлийн хяналт шалгалт хийх журмыг шинэчилж, хяналтын тогтолцоо, ажлын уялдааг боловсронгуй болгоно. | 2005 оноос | И. Эрдэнэбаатар |
| | | | 2. Гадаадын хөрөнгийн эх үүсвэрийн тусламжтайгаар "Байгаль орчны хяналтын менежмент, чадавхийг сайжруулах", "Уул уурхайн байгаль хамгаалал" төсөл хэрэгжүүлж, үр дүнг байгаль орчны хяналтын практикт нэвтрүүлнэ. | 2005 оноос | И. Эрдэнэбаатар |
| 20 | 1.1.20 | Засгийн газрын шийдвэрийн гүйцэтгэлд тавих хяналтыг боловсронгуй болгоно. | 1. Засгийн газрын шийдвэрийн гүйцэтгэлд хяналт тавих механизмыг боловсронгуй болгоно. | 2006 | С.Баярцогт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2. Хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. | 2006 | С.Баярцогт |
| | | | 3. Яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүн, нөлөөллийн шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгож, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, үр дүнг үнэлэхэд харгалзан үзнэ. | 2006-2008 | С.Баярцогт<br>Ж.Норовсамбуу |
| 21 | 1.1.21 | Хууль тогтоомж, стандартын биелэлтэд тавих мэргэжлийн хяналт, шалгалтыг чанаржуулан төрөөс иргэдэд үйлчлэх үйлчилгээний нэг төрөл болгоно. | 1. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох талаар санал, дүгнэлт, зөвлөмж гаргаж зохих байгууллагуудад тавьж шийдвэрлүүлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар<br>Сайд нар |
| | | | 2. Хууль хяналтын бусад байгууллага болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах ажиллагааг өргөжүүлнэ. | 2005 -2008 | И.Эрдэнэбаатар |
| 22 | 1.1.22 | Хяналт шалгалтын ажлыг баталгаажуулах зорилгод нийцүүлэн мэргэжлийн хяналтын байгууллагын лабораторийн чадавхийг сайжруулна. | 1. Хяналт шалгалтын ажлын баталгаажуулалтын түвшинг дээшлүүлэх зорилгоор лабораторийн шинжилгээний нэр төрөл, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 2. Улсын мэргэжлийн хяналтын газрын дэргэд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн марк, ангилал, хүчин чадал, ашиглах хугацаа, стандартын чанарын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлох хяналтын лабораторийг шинээр бий болгоно. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар<br>Сайд нар |
| **1.2. Төрийн удирдлага, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, нийгмийн баялгийг бүтээхэд оролцох иргэдийн эрх, боломжийг өргөжүүлэх, зүй ёсны төвлөрөлийг бодлогоор зохицуулах, түүхэн уламжлал, орчин цагийн шаардлагад нийцүүлэн засаг захиргааны нэгжийн өөрчлөлтийг цогц байдлаар хийнэ. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 23 | 1.2.1 | Иргэдэд үзүүлдэг эрүүл мэнд, боловсрол, харилцаа холбоо зэрэг зайлшгүй шаардлагатай төрийн үйлчилгээг хадгалах замаар одоогийн засаг захиргааны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах асуудлыг судалж шийдвэрлэнэ. | 1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчлэх санал боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллуулж, санал боловсруулна. | 2004.-2006 | Н.Батбаяр<br>Ч.Улаан<br>С.Баярцогт |
| | | | 2. Эдийн засаг, нийгэм, хууль эрх зүй, уламжлал, зан заншилтай холбогдсон асуудлаар санал боловсруулах ажлын дэд хэсгүүд байгуулан үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөний үндсэн дээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид өөрчлөлт оруулах асуудлыг төрийн үйлчилгээг чанартай хүргэх үйл ажиллагаатай холбон үзэж судалгаа, шинжилгээний ажил хийж гүйцэтгэнэ. | 2005–2006 | Н.Батбаяр<br>С.Баярцогт<br>Н.Алтанхуяг |
| 24 | 1.2.2 | Хөдөөнөөс хот, суурин газар руу чиглэсэн хүн амын шилжилт, хөдөлгөөнийг зах зээлийн аргаар зохицуулна. | 1. Монгол улсын бүлэг суурины төвүүдийн шинэ тогтолцоог боловсруулж шийдвэрлүүлнэ. | 2005-2007 | Н.Батбаяр<br>Ч.Улаан |
| 25 | 1.2.3 | Хүн ам олноор төвлөрч үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих боломжтой хот суурин, бүсийн төвүүдийг хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжинэ. | 1. Үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих боломж бүхий харьцангуй дэд бүтэц сайтай хотуудын судалгааг гарган хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих чиглэлийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Н.Батбаяр<br>Н.Алтанхуяг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2. Үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих боломжтой, хүн ам олноор төвлөрсөн хот суурин, бүсийн төвүүдийн мэдээлэл холбооны үйлчилгээний чанарыг сайжруулахад гадаад, дотоод, ялангуяа хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ. | 2005-2008 | С.Баярцогт |
| | | | 3. Бүсийн төв, тулгуур хотуудын орчимд тухайн бүсийн онцлог, дотоод гадаадын зах зээлийн эрэлтэд нийцсэн эрчимжсэн фермерийн аж ахуй, хоршоог хөгжүүлэхэд төрийн дэмжлэгийг чиглүүлнэ. | 2005-2008 | Д. Тэрбишдагва |
| | | | 4. Ховд, Улиастай, Эрдэнэт, Хархорин, Дархан, Зуунмод, Чойбалсан, Өндөрхаан, Улаанбаатарын тулгуур төвүүдийг хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, эдгээр хотуудыг шинэчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусган баталгаажуулж, жил бүрийн үндсэн чиглэл, улсын төсөвт тусган дэс дараатай хэрэгжүүлэх ажлыг дэмжин зохион байгуулна. | 2006-2008 | Н.Алтанхуяг<br>Ч.Улаан<br>Н.Батбаяр<br>Бүсийн зөвлөлүүд |
| | | | 5. Баруун бүсийн тулгуур төв Улиастай, Төвийн бүсийн тулгуур төв Дархан хот болон тэдгээрт таталцах бүс нутгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх урт хугацааны төсөл хэрэгжүүлэх асуудлаар гадаадын хандивлагчидтай яриа хэлэлцээ хийнэ. | 2005 оноос | Н.Алтанхуяг<br>Ч.Улаан<br>С.Батболд |
| 26 | 1.2.4 | Засаг захиргааны нэгжүүдийг эдийн засгийн хувьд бие даан хөгжих боломжоо нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогыг дэмжинэ. | 1. Орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор татварын зарим орлогыг орон нутагт шилжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ. | 2006 | Н.Алтанхуяг |
| | | | 2. Засаг захиргааны нэгжийн бие даасан хөгжлийг газар ашиглалтын бодлогоор дэмжиж, газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулан үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Н.Батбаяр |
| | | | 3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд нэгдэж томрох санал санаачилгыг дэмжиж, төсөв, санхүүгийн тодорхой дэмжлэг үзүүлэх журам боловсруулж шийдвэрлүүлнэ. | 2005 | Н.Алтанхуяг<br>С.Баярцогт |
| | | | 4. Шинээр тогтоогдсон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засгийн чадавхийг тодорхойлж, " Бүсийн хөгжлийн сан"-г байгуулах журам боловсруулж, мөрдүүлнэ. | 2005-2006 | Н.Алтанхуяг<br>Ч.Улаан<br>С.Батболд |
| 27 | 1.2.5 | Бүсүүдийн байршлын онцлог, давуу тал, хөгжлийн боломжид нь нийцсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 1. Бүсийн тулгуур төвүүд, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ нэгжийг хөгжүүлэх төслийг үе шаттайгаар боловсруулж хэрэгжүүлж эхлэнэ. | 2005-2008 | Н.Батбаяр<br>Ч.Улаан |
| | | | 2. Тэргүүлэх чиглэлийн зорилт, арга хэмжээг тухайн жилийн үндсэн чиглэлд тусган "Бүсийн хөгжлийн сан", "Бүсийн хэлэлцээр" байгуулах замаар дэмжин хэрэгжүүлэх үндсийг бүрдүүлнэ | 2005 оноос | Н.Алтанхуяг<br>Ч.Улаан<br>С.Баярцогт<br>Бүсийн зөвлөлүүд |
| | | | 3. Бүс нутаг бүрийн хөгжлийг түргэтгэхэд иргэд, төрийн бус байгууллагын эрх тэгш оролцоог хангах эдийн засаг, зохион байгуулалтын арга хэмжээг боловсруулна. | 2005 оноос | Н.Алтанхуяг<br>Ч.Улаан<br>С.Баярцогт<br>Бүсийн зөвлөлүүд |
| 28 | 1.2.6 | Нутгийн өөрөө удирдах болон захиргааны | 1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын | 2005-2006 | С.Баярцогт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгоно | тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авна. | | Ц.Нямдорж |
| 29 | 1.2.7 | Төрийн сүлд, далбаа, бэлгэдлийг иргэд өргөнөөр хүндэтгэн хэрэглэх, тэдэнд түүх, соёл, эх орноороо бахархах хүмүүжил олгохыг дэмжинэ. | 1. Төрийн сүлд, далбааг өргөнөөр хүндэтгэн хэрэглэх, эх орноороо бахархах хүмүүжил олгох чиглэлээр Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулна. | 2006 | С.Баярцогт<br>П.Цагаан |
| **1.3. Төрийн алба, нийгмийн амьдралыг хэт улс төржсөн, өрөөсгөл шалгуур, улс төрийн хуваагдмал байдлаас ангижруулж, төрийн албаны шалгуур нь зөвхөн мэргэшлийн болон уг албыг гүйцэтгэх чадвар, иргэдэд үйлчлэх үйлчилгээний чанар, түвшингээр тодорхойлогддог болгоно. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 30 | 1.3.1 | Төрийн жинхэнэ албан хаагчдыг намын харьяалалгүй болгож, улс төрийн албан тушаалын хамрах хүрээг багасгана. | 1. Төрийн жинхэнэ албан хаагч сонгуульд оролцсон тохиолдолд л үүрэгт ажлаасаа чөлөөлөгддөг байх асуудлыг Төрийн албаны тухай хуульд тусган өөрчлөлт оруулах замаар улс төрийн албан тушаалын хамрах хүрээг багасгана. | 2005 | Ц.Нямдорж<br>С.Баярцогт |
| | | | 2. Дипломат Төлөөлөгчийн Газрын тэргүүн улс төрийн албан тушаалтан байх тухай хуулийн заалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох саналаа эрх бүхий байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлнэ. | 2005 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 3. Тагнуулын байгууллагын ажилтан нь улс төрийн зорилгоор эвлэлдэн нэгдэх, улс төрийн үйл ажиллагаа явуулдаг эвсэл, холбооны гишүүн байх, албан үүргэтэйгээ холбоотой ямар ч мэдээ баримтыг улс төрийн зорилгоор ашиглахыг хориглох талаар холбогдох хууль тогтоомжид тусгана. | 2005 | С.Баярцогт |
| 31 | 1.3.2 | Төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн сонгуулийн сурталчилгаанд оролцох, түүнд зориулалтын бус төсвийн мөнгө, төрийн өмч хөрөнгийг дайчлах, машин унаа ашиглахыг хориглоно. | 1. Сонгуулийн сурталчилгааны өмнө төрийн жинхэнэ албан хаагчдын албан тушаалын жагсаалтыг хэвлэлээр нийтэлдэг жишиг тогтоож олон нийтийн хяналтын өмнө ил тод байлгана. | 2008 | С.Баярцогт<br>Ж.Норвсамбуу |
| 32 | 1.3.3 | Төрийн жинхэнэ албан хаагч нь төрийн аль нэг шатны сонгуульд нэр дэвшигчээр оролцох бол үүрэгт ажлаасаа чөлөөлөгддөг жишиг тогтооно | 1. Төрийн албаны тухай хууль болон Сонгуулийн хууль тогтоомжид холбогдох өөрчлөлтийг оруулна. | 2005 | С.Баярцогт<br>Ц.Нямдорж |
| 33 | 1.3.4 | Төрийн албанд ажилд орсон хүмүүсээс аль нэг намд гишүүнээр элсэхийг шаардах, гишүүнчлэлийн байдлыг асуух, шалгуур болгохыг хориглоно | 1. Төрийн албан хаагчдын ажлын шалгуур үзүүлэлтийг нээлттэй байлгана. Энэ шалгуур үзүүлэлтэд намын харьяаллын тухай мэдээлэл оруулахыг хориглоно. | 2005 оноос | С.Баярцогт<br>Ж.Норвсамбуу |

## Хоёр. НИЙГМИЙН БОДЛОГО

**Нийгмийн бодлогын үндсэн зорилт нь өрх гэрийг дэмжин тэтгэх, дундаж орлоготой хэсгийн хувийн жин болон иргэдийн худалдан авах чадварыг үлэмж нэмэгдүүлэх, хүний хөгжлийг бүх талаар дэмжихэд оршино. Дээрх бодлогын хүрээнд:**

**2.1. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн хамгааллыг сайжруулах зорилтуудыг уялдуулан зохицуулж, айл өрхийн амьжиргааг дэмжихэд чиглэсэн нийгэм, эдийн засгийн цогц бодлого хэрэгжүүлнэ.**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 34 | 2.1.1 | МАХН, "Эх орон – Ардчилал" эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон нийгмийн шинжтэй амлалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах зорилттой уялдуулан оновчтой, хаягласан, хүндэд хүрсэн хэлбэрээр хангахыг зорьж "Хүүхдийн мөнгө" хөтөлбөр хэрэгжүүлж эхэлнэ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд нэг хүнд ногдох орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур өрхийн гурав ба түүнээс дээш 0-18 насны хүүхэд бүрт сар тутам 3000 төгрөг олгоно. Уг мөнгийг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн олгож эхэлнэ. | 1. Амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой, 0-18 насны 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрхөд сар тутам хүүхэд бүрээр тооцож, хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох талаар Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулна. | 2005 | Ц.Баярсайхан |
| | | | 2. Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005 | Ц.Баярсайхан |
| | | | 3. Хүүхдийн эрхийг хангах санхүү, эдийн засгийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Хүүхдийн төлөө Үндэсний болон орон нутгийн зөвлөлийн дэргэд олон нийтийн үүсгэл санаачилгад тулгуурлан "Хүүхдийн төлөө сан" ажиллуулахыг дэмжинэ. | 2005 оноос | Ч.Улаан<br>Н.Алтанхуяг<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 4. Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журмыг Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу боловсруулж хэрэгжүүлнэ. | 2004-2005 | Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг |
| | | | 5. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах зорилттой уялдуулан "Хүүхдийн мөнгө" хөтөлбөрийг хэрэгжүүлэх, энэ хөтөлбөрийн хүрээнд нэг хүнд ногдох орлого нь амьжиргааны доод түвшингээс доогуур өрхийн 3 болон түүнээс дээш 0-18 насны хүүхэд бүрт сар тутам 3000 төгрөг олгоно. | 2005 | Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг |
| | | | 6. Айл өрхийн амьжиргааг хүүхдээр дамжуулан дэмжих нийгмийн бодлогын зорилтыг биелүүлэх суурь мэдээллийг бий болгоно. | 2006 | Ц.Баярсайхан<br>П.Бямбацэрэн |
| 35 | 2.1.2 | Ядуурал, ажилгүйдлийн талаар хийгдсэн судалгаанд үндэслэн түүнтэй тэмцэх бодлогыг хаягласан, үр дүнд тулгуурласан хэлбэрээр хэрэгжүүлнэ. | 1. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр явуулсан ажил эрхлэлтийн болон өрхийн амьжиргааны түвшин судалгаа, бусад сэдэвчилсэн судалгаануудын үр дүнд үндэслэн малчид, тахир дутуу хүмүүс, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүд, ахмад хүмүүс, ажилгүй залуучууд зэрэг зорилтот бүлгүүдэд тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний хэлбэрийг тодорхойлж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулна. | 2005 | Ц.Баярсайхан |
| | | | 2. Хөдөлмөрийн статистик мэдээг баяжуулж, ажил эрхлэлт, ажилгүйдлийн хэлбэрүүдийг бүрэн тодорхойлсон байдлаар гаргах арга хэмжээ авна. | 2005 | Ц.Баярсайхан<br>П.Бямбацэрэн |
| | | | 3. Нийгмийн халамжийн тусламж үйлчилгээг нийгэм хамт олонд түшиглэсэн зарчимд тулгуурлан өөрчлөх, халамжид хамрагдах хүрээг оновчтой тогтоох, шалгуур үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох чиглэлээр Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулна. | 2005 | Ц.Баярсайхан |
| | | | 4. Зорилтот бүлгүүдэд чиглэсэн үйлчилгээний арга зүйг боловсронгуй болгох, чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг АХБ-ны төслийн хүрээнд дэс дараатайгаар авна. | 2005 оноос | Ц.Баярсайхан |
| | | | 5. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийг устгах тухай АЙПЕК хөтөлбөр, Японы ядуурлыг бууруулах сангийн дэмжлэгтэй "Тахир дутуу хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" төслийг хэрэгжүүлнэ. | 2005 оноос | Ц.Баярсайхан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 6. Ядуурлыг бууруулах чиглэлээр хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх, энэ чиглэлээр хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслүүдийн нэгдсэн мэдээллийн сүлжээ бий болгоно. | 2005-2008 | Н.Алтанхуяг<br>Ц.Баярсайхан |
| | | | 7. Төсвөөс олгогдож байгаа хөрөнгө оруулалт санхүүжилт нь жендерийн тэгш бус байдлыг бий болгохгүй байхад чиглэсэн судалгаа, мониторинг хийж хэвшүүлнэ. | 2005-2008 | Н.Алтанхуяг<br>Ц.Баярсайхан |
| | | | 8. Хөдөлмөрийн багтаамж ихтэй, нийтийг хамарсан ажилд ажилгүй байгаа нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамруулах замаар түр ажлын байрыг бий болгоно. | 2005-2008 | Ц.Баярсайхан |
| 36 | 2.1.3 | Ядуурал, ажилгүйдэл, авилгалтай тэмцэх нь зөвхөн Засгийн газрын үүрэг гэсэн ойлголтыг өөрчилж, энэ чиглэлд орон нутагт эрх шилжүүлэх, хариуцлага үүрүүлэх тогтолцоог судалж хэрэгжүүлнэ. | 1. Ядуурал, ажилгүйдлийг бууруулахад орон нутгийн удирдлагын эрх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Ц.Баярсайхан<br>С.Баярцогт<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 2. Ажилгүй хүмүүсийн мэргэжлийн ур чадварын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн болон малчдад зориулсан сургалтыг ажлын байрны хэрэгцээтэй уялдуулан мэргэжлийн байгууллага, хүмүүсээр явуулна. | 2005-2008 | Ц.Баярсайхан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 3. Орон нутагт асрамж үйлчилгээний төвүүдийг байгуулан, асрамжийн үйлчилгээг өрх гэрт тулгуурласан хэлбэрт шилжүүлнэ. | 2005-2008 | Ц.Баярсайхан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 37 | 2.1.4 | Нийгмийн баялгийн хуваарилалтыг оновчтой, боловсронгуй болгоход чиглэсэн арга хэмжээг авилгал, хүнд сурталтай тэмцэх бодлоготой уялдуулж хэрэгжүүлнэ. | 1. Төсвийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах нийтлэг журам болон салбарын онцлогт нийцүүлсэн журмуудыг гаргаж мөрдөнө. | 2005-2008 | Н.Алтанхуяг<br>Сайд нар |
| | | | 2. Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгох, хянах, шалгах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ. | 2005-2008 | Ц.Баярсайхан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 3. Хүн амд үзүүлэх халамж, хөдөлмөр эрхлэлт, даатгалын үйлчилгээг засаг захиргааны нэгжид чиглүүлэх, "Нэг цэгийн үйлчилгээ" –г бий болгоно. | 2005-2008 | Ц.Баярсайхан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 38 | 2.1.5 | Хүн амын орлогын албан татварыг өрхийн нэг хүнд ногдох орлогын хэмжээ болон татвар ногдох орлогын түвшинтэй уялдуулна. | 1. Татварын шинэчлэлийн хүрээнд бага орлоготой иргэдэд үзүүлэх татварын хөнгөлөлтийг нэмэгдүүлнэ. | 2006-2007 | Н.Алтанхуяг |
| | | | 2. Өрх бүр жилд төлсөн хүн амын орлогын албан татварын тайлан, өрхийн орлогын мэдүүлгээ нэгтгэн гаргаж, нэг хүнд ногдох орлого нь тодорхой түвшингээс доогуур гарсан нөхцөлд татвараа буцаан авч болдог тогтолцоог нэвтрүүлэх арга хэлбэрийг судалж хэрэгжүүлэх санал боловсруулна. | 2006 | Н.Алтанхуяг |
| 39 | 2.1.6 | Гэр бүлд зориулсан үл хөдлөх хөрөнгө, ялангуяа орон сууцны зээлийн тогтолцоог бүрдүүлнэ. | 1. Залуу гэр бүл, оюутнуудад зориулсан орон сууцны цогцолбор, нийтийн байр барих талаар аж ахуй нэгж, байгууллагаас гаргасан санаачилгыг хөрөнгө оруулалтын зээлийн бодлогоор дэмжинэ. | 2005-2008 | Ц.Баярсайхан<br>Н.Батбаяр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 40 | 2.1.7 | Хувийн орон сууцтай болох, орон сууцаа өргөтгөн сайжруулах явдлыг дэмжихийн хамт, орон сууцны дэд бүтцийг тэргүүн ээлжинд байгуулах арга хэмжээ авна. | 1. Бизнесийн байгууллага, иргэдийн хөрөнгө оруулалтаар бий болгосон орон сууцны дэд бүтэц бүхий газрын харилцааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2005-2008 | Н.Батбаяр |
| | | | 2. Улаанбаатар, Дархан, Зуунмод болон бусад аймгийн төвд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө болон гадаадын ээл тусламж, аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгө оруулалтаар орон сууцны дэд бүтцийг барьж байгуулна. | 2005-2008 | Н.Батбаяр |
| | | | 3. Орон сууцны дэд бүтцийг барьж байгуулах, ашиглахад оруулсан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт үзүүлж эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх талаар холбогдох хуулийн төсөл , эрх зүйн баримт бичгийг боловсруулж мөрдүүлнэ. | 2005-2008 | Н.Батбаяр<br>Н.Алтанхуяг |
| 41 | 2.1.8 | Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсооход чиглэсэн сургалт, сурталчилгааг өргөтгөж, хамгаалах үйлчилгээ, үйл ажиллагаар хүртээмжтэй, үр өгөөжтэй болгохын тулд иргэний нийгмийн санаачилга, оролцоог идэвхтэй дэмжинэ. | 1. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг иргэний нийгэмтэй хамтран сургалт, сурталчилгаа явуулна. | 2005-2008 | Ц.Баярсайхан |
| | | | 2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийг засан хүмүүжүүлэх сэтгэл зүй, сургалтын төв байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008 | Ц.Баярсайхан |
| 42 | 2.1.9 | Хүн ам зүйн асуудлыг цогцоор авч үзэж өвчлөл, нас баралтыг бууруулах, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, зах зээлийн эрэлт хэрэгцээ, нийгмийн шаардлагатай уялдсан хүн амын байршлыг дэмжиж, шилжих хөдөлгөөнийг зохистой удирдах арга хэмжээг гэр бүл төвтэй бодлоготой уялдуулан дэс дараатай авч хэрэгжүүлнэ. | 1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан хүн амын байршилт, шилжих хөдөлгөөнийг оновчтой зохицуулах эдийн засгийн хөшүүргийг судлан тогтоож, бүсүүдийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2006 оноос | Н.Алтанхуяг<br>Ч.Улаан<br>Ц.Баярсайхан<br>Бүсийн зөвлөлийн дарга |
| | | | 2. Хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн санг баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлд байгуулж, нэгдсэн сүлжээнд оруулна. | 2005-2008 | С. Баярцогт<br>П. Бямбацэрэн |
| | | | 3. Залуучуудын гэр бүлийн талаарх мэдлэг, ойлголт, хандлагыг дээшлүүлэх талаар төрийн бус байгууллагын оролцоотойгоор сургалт, сурталчилгааг эрчимжүүлнэ | 2005-2008 | Ц.Баярсайхан |
| **2.2. Ерөнхий боловсролын түвшнээр Монгол Улсын нэгэнт хүрсэн амжилтыг улам бататган чанаржуулж, боловсролын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж сургалт, судалгааны ажлыг үйлдвэрлэл, хэрэглээтэй нягт холбож, иргэдийн сурч боловсрох эрхээ чөлөөтэй эдлэхэд нь илүү өргөн боломж бүрдүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 43 | 2.2.1 | Боловсрол, шинжлэх ухаан, технологийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлнэ. | 1. Боловсролын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна. | 2005 | П.Цагаан |
| | | | 2. Шинжлэх ухаан, технологийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна. | 2005 | П.Цагаан |
| | | | 3. Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлж эхэлнэ. | 2004-2005 | П.Цагаан |
| 44 | 2.2.2 | Монгол Улсын боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулна. | 1. Монгол Улсын боловсролын өнөөгийн байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гаргана. | 2005 | П.Цагаан |
| | | | 2. Боловсролын цаашдын хөгжлийн төлөв, зорилтыг тодорхойлсон мастер төлөвлөгөө боловсруулна. | 2005 | П.Цагаан |
| | | | 3. Монгол Улсын боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлнэ. | 2006-2008 | П.Цагаан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 45 | 2.2.3 | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, байршлыг болон дотуур байрны байршил, хангамжийг оновчтой болгоно. | 1. Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны байршил, хүчин чадлын судалгаа гаргана. | 2005 | П.Цагаан Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 2. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн өөрчлөлттэй холбоотойгоор ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, хэв шинж,, байршлыг оновчтой болгох, дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг сайжруулах санал боловсруулж шийдвэрлүүлнэ. | 2006 | П.Цагаан Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 46 | 2.2.4 | Багшийн мэргэжлийн чадавхи, үнэлэмжийг дээшлүүлнэ. Боловсролын салбарт хийх улсын төсвийн санхүүжилтийг багш нарт түлхүү зарцуулж, удирдлагын зардлыг бууруулна. | 1. Багшийн мэргэжлийн сургалтын агуулгыг шинэ стандартад нийцүүлэн боловсронгуй болгоно. | 2005 | П.Цагаан |
| | | | 2. Бүх шатны сургуулийн багш нарт компьютерийн хэрэглээний программ болон англи хэлний шаталсан боловсрол олгох арга хэмжээг төлөвлөгөөний үндсэн дээр хэрэгжүүлж эхэлнэ. | 2005 | П.Цагаан |
| | | | 3. Багшийн үйл ажиллагааг суралцагч, эцэг, эх, хөндлөнгийн болон сургуулийн удирдлагын үнэлгээнд тулгуурлан дүгнэх журам боловсруулж хэрэгжүүлнэ. | 2006 | П.Цагаан |
| | | | 4. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөдөлмөрийн үнэлэмжийг бодитой болгож, тэдгээрийн цалин, нэмэгдэл хөлсний тогтолцоог шинэчлэн мөрдүүлнэ. | 2006 | П.Цагаан Ц.Баярсайхан |
| | | | 5. Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төв, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн зарим ажил үйлчилгээг гэрээ, түрээсийн хэлбэрт шилжүүлнэ. | 2006 | П.Цагаан |
| | | | 6. Боловсролын удирдах ажилтны менежментийн чадавхийг дээшлүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ. | 2005 | П.Цагаан |
| 47 | 2.2.5 | Ерөнхий боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлж, 12 жилийн тогтолцоонд шилжих бэлтгэлийг хангана. | 1. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын шинэчилсэн стандартыг хэрэгжүүлж эхэлнэ. | 2005 | П.Цагаан |
| | | | 2. Ерөнхий боловсролын сургуулийг 11 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлнэ. | 2005 | П.Цагаан |
| | | | 3. Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэхтэй холбогдуулан сургуулийн хичээлийн болон дотуур байрын суудлын тоо, багшийн хангамж, төсөвт зардал зэрэг асуудлаар судалгаа хийж, шилжүүлэх бэлтгэл ажлыг төлөвлөгөө, графикийн дагуу хэрэгжүүлнэ. | 2006-2008 | П.Цагаан |
| | | | 4. Бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг 12 жилийн тогтолцоонд нийцүүлэн өөрчилнө. | 2007 | П.Цагаан |
| | | | 5. Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжихтэй холбогдуулан боловсролын удирдах ажилтан, багш нарт зориулсан сургалтууд зохион байгуулна. | 2007 | П.Цагаан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 48 | 2.2.6 | Стандартын сурах бичгээс сонголт хийх эрхийг эцэг эх, сургуулийн захиргаа хамтран эдлэх явдлыг тус тус дэмжинэ. | 1. Сурах бичгийн талаар баримтлах бодлого, сурах бичгийн стандарт, сурах бичиг зохиох, хэвлэх, түгээх журмыг шинэчлэн гаргаж, сурах бичгээс эцэг эх, багш, сургуулийн захиргаа хамтран сонголт хийх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | 2005 | П.Цагаан |
| | | | 2. Хэвлэлийн газар тевтэй сурах бичгийн хангамжийн шинэ тогтолцоог бий болгоно. | 2005 | П.Цагаан |
| | | | 3. Эмээг бүтгийн болон бага орлоготой өрхийн суралцагчид сурах бичиг худалдан авах эрхийн бичиг олгох асуудлыг шийдвэрлэнэ. | 2005 | П.Цагаан |
| | | | 4. Шинэ стандартын дагуу ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгүүдийг шинэчилнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| 49 | 2.2.7 | Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын шинэчилсэн стандартыг хэрэгжүүлж бага, дунд боловсролын тогтолцоог шинэчлэн сургуулийн өмнөх болон суурь боловсролын хамралтыг нэмэгдүүлнэ. | 1. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг олон хэлбэрээр зохион байгуулж, хамралтыг нэмэгдүүлнэ. | 2005-2007 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 2. Ерөнхий боловсорлын сургуулийн 1 дүгээр ангид элсэх хүүхдийг бүрэн хамруулах, сургууль завсардалтыг бууруулах замаар суурь боловсролын хамралтыг нэмэгдүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 3. Бүх нийтийн боловсролын хөтөлбөр /2005-2015 он/ боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 4. Англи хэлний суурь болон бүрэн дунд боловсролын стандартыг тогтоох шалгалтыг улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар зохион байгуулж, үр дүнд нь дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргана. | 2005-2007 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 5. Зах хязгаар нутгийн болон малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах хувьсах зардлыг шийдвэрлэж, явуулын багштай нүүдлийн болон гэр цэцэрлэг ажиллуулна. | 2005-2008 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 50 | 2.2.8 | Англи хэлийг хоёр дахь албан хэл болгох бэлтгэлийг хангахын тулд зохих өөрчлөлтийг сургалтын хөтөлбөрт оруулан, багш бэлтгэхэд хөрөнгө оруулалт хийж, сайн дурын багш нарын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | 1. Бүх шатны англи хэлний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулна. | 2005 | П.Цагаан |
| | | | 2. Англи хэлний багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэхэд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 3. Сайн дурын багш нарыг нэмэгдүүлэх асуудлаар гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийг өргөжүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 4. Англи хэл заах гадаадын сайн дурын багш нарын тоог нэмэгдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын шугамаар ажиллана. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 5. Ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургуулийн оюутан сурагчдын дунд англи хэлний олимпиад, Англи хэлний баяр, орчуулгын уралдаан жил бүр зохион байгуулж байх. Англи хэлээр унших хүүхдийн ном, хэвлэлийг нэмэгдүүлнэ. | 2006–2008 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 51 | 2.2.9 | Суурь болон бүрэн дунд боловсролын англи хэлний сургалтыг өргөжүүлж, чанаржуулна. | 1. Бага, дунд боловсролын англи хэлний боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулна. | 2005 | П.Цагаан |
| | | | 2. Англи хэлний сурах бичгийг шинэчилнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 3. Ерөнхий боловсролын сургуулиудын англи хэлний сургалтын орчинг сайжруулна. | 2005-2008 | П.Цагаан |
| 52 | 2.2.10 | Англи хэлээр эрдмийн зэрэг хамгаалах болон англи хэл, байгалийн шинжлэл, инженер, мэдээллийн технологийн чиглэлээр явуулах сургалтын нэвтрүүлгийг дэмжинэ. | 1. Англи хэлээр эрдмийн зэрэг хамгаалахыг дэмжиж, холбогдох журамд өөрчлөлт оруулна. | 2005 | П.Цагаан |
| | | | 2. Англи хэл, байгалийн шинжлэл, мэдээллийн технологийн чиглэлээр явуулах сургалтын нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрийг боловсруулж, зардлыг санхүүжүүлэх арга хэмжээ авна. | 2006 | П.Цагаан |
| | | | 3. Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд зориулсан төрөл бүрийн сургалт, танин мэдэхүйн нэвтрүүлэг явуулдаг телевизийг иргэн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж , олон улсын байгууллагын дэмжлэг туслалцаатай байгуулна. | 2005-2008 | П.Цагаан |
| 53 | 2.2.11 | Мэргэжлийн болон эчнээ, алсын зайн сургалтыг өргөжүүлнэ. | 1. Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвүүдийн менежмент, сургалтын орчинг сайжруулж, элсэгчдийн тоог нэмэгдүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Ц.Баярсайхан |
| | | | 2. Зарим их сургуулийг түшиглэн зайны сургалтыг зохион байгуулна. | 2006-2008 | П.Цагаан |
| | | | 3. Зайны сургалтын улсын нэгдсэн сүлжээ байгуулан багшийн мэргэшлийг дээшлүүлэх, бага хурал зохион байгуулах зэрэг бусад зайны сургалтад ашиглана. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 4. Их, дээд сургуулиудын эчнээ сургалтын өнөөгийн байдалд үнэлгээ өгч, зарим мэргэжлээр эчнээ сургалтыг өргөтгөнө. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 5. Удирдлагын академийн сургалтад зайн сургалтын технологийг нэвтрүүлж энэ ажлын хүрээнд туршилтын журмаар 3 аймагт зайны сургалтын төв байгуулан ажиллуулж эхлүүлнэ. | 2005 | С. Баярцогт |
| | | | 6. Удирдлагын академид заасаж байгаа хичээлүүдийг цахим хэлбэрээр бэлтгэж зайн сургалтын шаардлагад нийцүүлэн боловсруулна. Ингэхдээ төрийн захиргааны болон удирдахуйн ухааны суурь хичээлүүдийг тэргүүн ээлжинд зайн сургалтад зориулан бэлтгэж сургалт явуулж эхэлнэ. | 2005-2008 | С. Баярцогт |
| 54 | 2.2.12 | Сургууль завсардсан хүүхэд буюу сургуульд суралцаж чадаагүй насанд хүрэгчдэд заавал олгогдох боловсролыг нөхөн олгохоор ажиллаж буй иргэний нийгмийн санаачилгыг дэмжинэ. | 1. Иргэд, төрийн бус байгууллагаас бичиг үсэг сургах, боловсрол нөхөн олгох сургалт явуулахад дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно. | 2005 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 2. Иргэд, төрийн бус байгууллагаас хүүхэд, насанд хүрэгчдэд бичиг үсэг сургах, боловсрол нөхөн олгох үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлэхийг дэмжинэ. | 2005-2007 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3. Сургууль завсардсан болон бүрэн бус дунд сургууль төгссөн хүүхдийг үргэлжлүүлэн сургахад, эчнээ болон оройн сургуулийн хэлбэр, мэргэжлийн курс дамжаат өргөн ашиглана. | 2006-2008 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 55 | 2.2.13 | Эмээг бүлийн, бага орлоготой өрхийн болон 3 ба түүнээс дээш хүүхэд нь зэрэг сурдаг өрхийн 1 хүүхдэд хичээлийн хэрэгсэл үнэ төлбөргүй олгож байгааг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 1. Эмээг бүлийн, бага орлоготой өрхийн болон 3 ба түүнээс дээш хүүхэд нь зэрэг сурдаг өрхийн нэг хүүхдэд хичээлийн хэрэгсэл үнэ төлбөргүй олгоно. | 2005-2008 | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| 56 | 2.2.14 | Инженер, технологийн боловсролыг тэрээс тусгайлан дэмжиж, ийм боловсрол олгоход зориулж хувийн хэвшлээс оруулах хөрөнгө оруулалтыг урамшуулна. | 1. Заслийн газар хоорондын хэлэлцээр, буцалтгүй тусламжийн хүрээнд гадаад оронд суралцагчдын дотор инженер, технологийн мэргэжил эзэмшигчдийн хувийн жинг жил бүр нэмэгдүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Н.Алтанхуяг<br>Ц.Мөнх-Оргил |
| | | | 2 Инженер, технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудын сургалтын орчныг сайжруулахад гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийг нэмэгдүүлнэ. | 2006-2008 | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| 57 | 2.2.15 | Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг олон улсын стандартад нийцүүлэхийг зорьж ажиллана. | 1. Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн байгууллагын чиг үүргийг олон улсын нийтлэг жишигт нийцүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 2. Сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд тавих шаардлага, шалгуурыг боловсронгуй болгож мөрдүүлнэ. | 2006-2008 | П.Цагаан |
| 58 | 2.2.16 | Боловсролын салбарт менежментийн хувьчлалыг үргэлжлүүлнэ. | 1. Менежментийн хувьчлалд хамруулах төрийн өмчийн сургалтын байгууллагын жагсаалтыг жил бүр гаргана. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 2. Жагсаалтын дагуу хувьчлах үйл ажиллагаа зохион байгуулна. | 2005-2008 | П.Цагаан |
| 59 | 2.2.17 | Их, дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажилд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн хэм хэмжээ мөрдөх явдлыг хөхиүлэн дэмжиж, сургалт, судалгааны ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарна. | 1. Их, дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажилд баримтлах ёс зүйн дүрмийг боловсруулж мөрдүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| 60 | 2.2.18 | Мэдээллийн технологийг дээд, дунд шатны боловсролын сургалтад нэвтрүүлнэ. | 1. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын мэдээллийн технологийн техникийн баазыг үе шаттайгаар бий болгоно. | 2004-2008 | П.Цагаан |
| | | | 2. Мэдээллийн технологи ашиглан хичээл заах талаар багш нарт зориулсан сургалт зохион байгуулж, сургалтын материал, гарын авлага бэлтгэнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 3. Зарим мэргэжлийн хичээлийг мэдээллийн технологи ашиглан зааж эхэлнэ. | 2006-2008 | П.Цагаан |
| 61 | 2.2.19 | Монгол Улсын дээд боловсролын өрсөлдөх чадвар, үнэлэмжийг дээшлүүлнэ. | 1. Дээд боловсролын сургалтын агуулга, стандартыг боловсронгуй болгон шинэчлэнэ. | 2005-2007 | П.Цагаан |
| | | | 2. Дээд боловсролын сургалтын байгууллагыг үе шаттай аттестатчилна. | 2006-2008 | П.Цагаан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3. Их, дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн баазыг шинэчлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 4. Их, дээд сургууль, коллежийн багш нарын англи хэл, компьютерийн мэдлэгийн түвшинг тогтоож, түүнийг ахиулах арга хэмжээ зохион байгуулна. | 2005 | П.Цагаан |
| | | | 5. Их, дээд сургууль, коллежийн багш нарын ажлыг үнэлэх журмыг боловсронгуй болгоно. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 6. Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн журам, үнэлгээний механизмыг боловсронгуй болгоно. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 7. Боловсролын баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг үргэлжлүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 8. Дээд боловсролын сургалтын байгууллагын рейтинг тогтоож, нийтэд мэдээлдэг болно. | 2005-2008 | П.Цагаан |
| 62 | 2.2.20 | Сурагч, оюутны дүнгийн нууцлалыг хадгалах тогтолцоог туршин нэвтрүүлж эхэлнэ. | 1. Сурагч, оюутны дүнгийн нууцлалыг хадгалах эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авна. | 2005-2006 | П.Цагаан |
| | | | 2. Сурагч, оюутны дүнгийн нууцлалыг зарим сургуульд туршин хэрэгжүүлж эхэлнэ. | 2006-2008 | П.Цагаан |
| 63 | 2.2.21 | Ажил, хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ суралцах хүсэлтэй хүмүүст зориулсан "Олон нийтийн нээлттэй их сургууль"-ийн аливаа хэлбэрийг дэмжинэ. | 1. Гадаад орны нээлттэй их сургуулийн үйл ажиллагааны туршлагыг судалж, нийтэд сурталчилна. | 2006 | П.Цагаан |
| | | | 2. Нээлттэй их сургууль байгуулах үүсгэл санаачилгыг дэмжиж, арга зүйн туслалцаа үзүүлнэ. | 2006-2008 | П.Цагаан |
| 64 | 2.2.22 | Мэргэжлийн боловсролын агуулга, стандартыг шинэчлэн, сургалтын орчныг бэхжүүлэх, нийгмийн түншлэлийг идэвхжүүлэх замаар сургалтын чанарыг дээшлүүлж, мэргэжлийн боловсролыг тулхүү хөгжүүлнэ. | 1. Мэргэжлийн боловсролын агуулга, стандартыг шинэчлэн мөрдөнө. | 2005-2008 | П.Цагаан<br>Ц.Баярсайхан |
| | | | 2. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш , ялангуяа дадлагын багшийн мэргэжил, ур чадварт тавигдах шаардлагыг дээшлүүлж, тэдгээрийг сургаж чадваржуулах ажлыг өргөжүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Ц.Баярсайхан |
| | | | 3. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын мэргэжлийн чиглэлийг харгалзан сургалтын орчин, дадлагын баазыг бэхжүүлнэ | 2005-2007 | П.Цагаан<br>Ц.Баярсайхан |
| | | | 4. Нийгмийн түншлэлийг идэвхижүүлэх механизмыг бий болгож хэрэгжүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Ц.Баярсайхан |
| | | | 5. Эрх зүйн дээд боловсролын агуулга, стандартыг шинэчилнэ. | 2005- 2008 | Ц.Нямдорж |
| | | | 6. Нарийн мэргэжлийн ажилчид бэлтгэх, давтан сургах тогтолцоо бүрдүүлэх талаар ажиллана. | 2005 | С.Батболд<br>Ц.Баярсайхан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 65 | 2.2.23 | Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлтийг хэвийн, сурагчдад ойр байлгах явдлыг хот байгуулалтын үндсэн шаардлагын нэг шалгуур болгон тооцдог болно. | 1. Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлтийн байдалд үнэлгээ өгнө. | 2005 | П.Цагаан<br>Н.Батбаяр |
| | | | 2. Ачаалал ихтэй сургуулийн хичээлийн байрыг өргөтгөх, шинээр барих асуудлыг хот байгуулалтын бодлоготой уялдуулан үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Н.Батбаяр |
| 66 | 2.2.24 | Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт - үйлдвэрлэлийн төвийг тогтоосон стандартын дагуу компьютержүүлж, сүлжээнд холбох ажлыг ээлж дараатайгаар хэрэгжүүлнэ. | 1. Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн компьютер хангамжийн стандарт боловсруулна. | 2005 | П.Цагаан |
| | | | 2. Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг тогтоосон стандартын дагуу компью-терждүүлэх, сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| 67 | 2.2.25 | Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байр, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх, засварлах ажлыг зохион байгуулж, сургуулийн ачааллыг багасгана. | 1. Аймгийн төв, зарим суурин газруудад ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр шинээр барих, өргөтгөх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| | | | 2. Сургууль, цэцэрлэгийн барилгыг улсын төсөв, зээл тусламжаар засварлах ажлыг үргэлжлүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| | | | 3. Ерөнхий боловсролын сургуульд гадаадын болон хувийн хөрөнгө оруулалт хийх, сургалтын чанарыг дээшлүүлэх санаачилгыг дэмжинэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| | | | 4. Сургуулиудын ачааллыг бууруулах зорилгоор хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургууль байгуулахыг дэмжинэ. | 2005-2008 | П.Цагаан |
| 68 | 2.2.26 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг сурах боломжоор хангаж, зориулалтын тоног төхөөрөмж, нэхцэл бүхий сургууль, анги танхимын хүрэлцээг нэмэгдүүлнэ. | 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношлох, үнэлэх арга зүй боловсруулна. | 2005 | П.Цагаан<br>Т.Ганди<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын сурах боломжоор өргөжүүлж, зориулалтын тоног төхөөрөмж бүхий сургууль, анги танхимын хүрэлцээг нэмэгдүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 69 | 2.2.27 | Төрөөс суралцагчдад үзүүлж байгаа сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийн тогтолцоог шинэчилнэ. | 1. Их, дээд сургууль, коллежид сурч байгаа өнчин, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нарт сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгоно. | 2006-2008 | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| | | | 2. Их, дээд сургууль, коллежид суралцагчдад олгох хөнгөлөлттэй зээлийг бусад орны жишгээр банкны зээлийн тогтолцоонд оруулах асуудлыг судлан боловсруулж шийдвэрлэнэ. | 2005-2007 | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| 70 | 2.2.28 | Оюутнуудад зориулан оюутны байр, хотхон байгуулах санаачилгыг болон хотхоны хэлбэрээр үйл ажиллагаагаа цогц явуулах их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг дэмжинэ. | 1. Оюутны хотхон байгуулах, оюутны байр барих үйл ажиллагаанд банкны хөнгөлөлттэй зээл олгох, үнэ төлбөргүй газар эзэмшүүлэх, гадаадаас оруулсан барилгын материал, тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт үзүүлэх зэргээр дэмжих эрх зүйн зохицуулалтыг бий болгоно. | 2006 | П.Цагаан<br>Н.Батбаяр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2. Хотхоны хэлбэрээр үйл ажиллагаа явуулах их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдэд зохих дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Н.Батбаяр |
| 71 | 2.2.29 | Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад эрдэм шинжилгээний боловсон хүчин, залуу эрдэмтдийг бэлтгэхийн зэрэгцээ гадаадын нэр хүндтэй их сургууль, коллежийн салбарыг дотооддоо байгуулах, чанартай боловсрол үйлдвэрлэх, экспортлох санаачилгыг дэмжинэ. | 1. Гадаад оронд эрдэм шинжилгээний боловсон хүчин бэлтгэх мэргэжлийн чиглэл, хяналтын тоог тогтооно. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 2. Мэргэжлийн чиглэл, хяналтын тооны дагуу гадаадад суралцуулах хүмүүсийг сонгон шалгаруулах, суралцуулах ажлыг зохион байгуулна. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 3. Гадаадын нэр хүндтэй зарим их сургууль, коллежийн салбарыг Монголд байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 4. Дотоодын их, дээд сургуульд гадаад орноос суралцагчдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | П.Цагаан |
| 72 | 2.2.30 | Хот, суурин газруудад иж бүрэн үйлчилгээ бүхий "Номын өргөө" байгуулах санаачилга дэвшүүлж, эрх зүйн болон санхүүжилтийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ. | 1. Номын өргөөний зохион байгуулалт, үйлчилгээний төрөл, хэлбэр, санхүүжилтийн механизмыг тогтооно. | 2006 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 2. Аймаг, нийслэлийн зарим номын санг "Номын өргөө" болгон зохион байгуулна. | 2007-2008 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 3. "Виртуаль номын сан" төсөл боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2007 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| **2.3. Шинжлэх ухаан, технологийн дэвшлийг үндэсний эдийн засгийг хөгжүүлэх, хүн амын амьдралын чанарыг сайжруулахад нэн түрүүн чиглүүлэх, оюуны шинэ бүтээлийн эрэлтийг нэмэгдүүлж, түүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, капитал болгоход чиглэсэн бодлогыг цогцоор хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 73 | 2.3.1 | Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулна. | 1. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн өнөөгийн байдалд үнэлгээ өгнө. | 2005 | П.Цагаан |
| | | | 2. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх Мастер төлөвлөгөө боловсруулж батална. | 2006 | П.Цагаан |
| 74 | 2.3.2 | Шинжлэх ухаан, технологийн үндэсний чадавхийг улс орны хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглүүлэн улс орны хөгжилд бодитой нөлөө үзүүлж чадах судалгаа, шинжилгээний ажлын чиглэлийг нарийвчлан тогтоож, эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгоно. | 1. Эрдэм шинжилгээний ажлын тэргүүлэх чиглэлийг тогтооно. | 2006 | П.Цагаан |
| | | | 2. Эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтийг нийгэм, эдийн засгийн хөгжил, зах зээлийн эрэлтэд чиглүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 3. Шинжлэх ухаан, технологийн төслийг олон эх үүсвэрээс санхүүжүүлэх, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төслийн шалгаруулалтад хувийн секторыг хамруулах арга хэмжээ авна. | 2005-2008 | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| 75 | 2.3.3 | Шинжлэх ухааны байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлэн эрдэм шинжилгээний лабораториудын тоног төхөөрөмжийг | 1. Эрдэм шинжилгээний байгууллагуудын тоног төхөөрөмжийн өнөөгийн байдалд үнэлгээ өгч, шинэчлэх чиглэлийг тодорхойлно. | 2005-2006 | П.Цагаан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шинэчлэх, орчин үеийн оношлогооны багажаар хангах замаар судалгааны өгөөж, үр нөлөөг дээшлүүлнэ. | 2. Эрдэм шинжилгээний лабораториудын тоног төхөөрөмжийг шинэчлэх, орчин үеийн оношлогооны багаж, хэрэгслээр хангах арга хэмжээг улсын төсөв болон олон улсын байгууллага, хандивлагч орнуудтай хамтарсан хөтөлбөр, төсөлд тусгах замаар хэрэгжүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| 76 | 2.3.4 | Дотооддоо баталгаажсан шинэ бүтээл, оюуны өмчийг дотоодын зах зээл дээр найдвартай хамгаалах тогтолцоог бий болгон мөрдүүлнэ. | 1. Эрхийн хамгаалалттай шинэ бүтээл, оюуны өмчийн ашиглалт, эрхийн хамгаалалтын зөрчлийн байдалд судалгаа хийж, үнэлгээ өгнө. | 2005 | Ч.Улаан |
| | | | 2. Шинэ бүтээл, оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулах талаар патентын болон зохиогчийн эрхийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдүүлнэ. | 2006-2008 | Ч.Улаан |
| | | | 3. Патентийн эрхийн хамгаалалт хийхтэй холбоотой дүрэм, журмуудыг шинэчлэн батална, мөрдүүлнэ. | 2006 | Ч. Улаан |
| | | | 4. Оюуны өмчийн тухай багц хуулиудад оюуны өмч эзэмшигч, ашиглагчдын хоорондын харилцааг боловсронгуй болгох чиглэлээр өөрчлөлт оруулах санал боловсруулна. | 2005-2008 | Ч.Улаан<br>С.Батболд |
| | | | 5. Хүүхэд, залуучуудын үүсгэл санаачилга, оюуны бүтээлийг багаас нь баталгаажуулж урамшуулдаг үндэсний болон орон нутгийн тогтолцоо бүрдүүлж төлөвшүүлнэ. | 2006-2008 | Ч.Улаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 77 | 2.3.5 | Бизнесийн захиалгат судалгааны ажлыг дэмжинэ. Ялангуяа, шинэ зах зээл нээх, уламжлалт зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлын нууцлалыг хамгаалах, захиалагч, оюуны бүтээлийн хамтран өмчлөгчдийн эрх, үүргийг тодорхойлж, эрх ашгийг нь хамгаалсан эрх зүйн зохицуулалтыг бий болгож мөрдүүлнэ. Ингэснээр шинжлэх ухааны судалгаа, нээлтийн санхүүжилтийн дийлэнхийг хувийн хэвшил хангадаг жишигт шилжинэ. | 1. Бизнесийн захиалгат судалгааны ажлыг гэрээ-захиалгаар хэрэгжүүлдэг механизм бий болгоно. | 2006-2008 | Ч.Улаан |
| | | | 2. Оюуны бүтээлийг хамтран өмчлөгчдийн эрх, үүргийг тодорхой болгох, эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт оруулна. | 2006 | Ч.Улаан<br>Ц.Нямдорж |
| | | | 3. Иргэний хууль, Патентийн тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар оюуны бүтээл хамтран өмчлөгчдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. | 2006 | Ч. Улаан |
| | | | 4. Уламжлалт мэдлэгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 2007 | Ч. Улаан |
| | | | 5. Уламжлалт технологийг аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтаар хамгаалах эрх зүйн орчинг бий болгоно. | 2006 | Ч. Улаан |
| | | | 6. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2005-2008 | С.Батболд |
| 78 | 2.3.6 | Гэр ахуй, өргөн хэрэглээ, дулаан, цэвэр, бохир ус, түлш , цахилгаан шугам сүлжээ, мэдээлэл харилцаанд дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг дэмжиж таатай нөхцөл бүрдүүлэхийг зорино. | 1. Цахилгаан, дулаан, ус хангамжийг сайжруулахад чиглэсэн гадаад орны технологи нэвтрүүлэх, нутагшуулах арга хэмжээг дэмжинэ. | 2005–2008 | С.Батболд<br>Т.Очирхүү |
| | | | 2. Дотоодын эрдэм шинжилгээний төсөлт ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2005–2008 | П.Цагаан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3. Ус, түлш, дулаан, цахилгаан эрчим хүчний тооцоонд ашиглахаар импортоор оруулж байгаа ахуйн зориулалтын электрон хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын төлбөрийн хэмжээг багасгах, баталгаажуулалт хоорондын хугацааг уртасгах асуудлыг судлан олон улсын жишигт нийцүүлэх замаар дэвшилтэт технологи нэвтрүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлнэ. | 2005 | Ч. Улаан |
| 79 | 2.3.7 | **Усны хатуулаг, эрдэсжилт ихтэй сумын төв, суурин газруудад ус зөөлрүүлэх төхөөрөмж** суурилуулах ажлыг үргэлжлүүлж, хүн амын ундны усны чанарыг сайжруулна. | **1. Хатуулаг, эрдэсжилт ихтэй ус хэрэглэгддэг зарим сумын төвд ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулах замаар хүн амыг** эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах ажлыг дэмжинэ. | 2005–2008 | Н. Батбаяр |
| | | | 2. Хандивлагч орнуудын тусламжаар ус зөөлрүүлэх, цэвэршүүлэгч тоног төхөөрөмжийг усны чанарын шаардлага хангахгүй эх үүсвэрүүд дээр тавина. | 2005-2007 | Н.Батбаяр<br>Н.Алтанхуяг |
| | | | 3. Ундны усны нөөц багатай төв, суурин газруудад ундны болон ахуйн хэрэгцээний усны хос шугамтай болгох судалгаа тооцоо хийж санал, төсөл боловсруулна. | 2005-2008 | Н.Батбаяр |
| | | | 4. Нийслэл, бүсийн тулгуур төв, аймгийн төвүүдийг ус хэмнэлтийн бодлого, хөтөлбөртэй болгож хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Н.Батбаяр |
| 80 | 2.3.8 | Улсын захиалгаар хийгдэх урт болон богино хугацааны төслүүдийг шинжлэх ухааны байгууллагуудаар хийх ажлыг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэн өөрчилнө. | 1. Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журмыг шинэчлэн мөрдүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 2. Улсын эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ байгуулан таримал ургамлын сайн чанарын үр үйлдвэрлэх ажлыг зохион байгуулна. | 2005-2008 | Д.Тэрбищдагва |
| 81 | 2.3.9 | Улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэлийн салбаруудад технологийн инкубатор, технологи дамжуулах төвийн зохистой бүтэц, механизмыг бий болгон хөгжүүлнэ. | 1. Шинээр инкубатор байгуулах ажлыг ээлж дараатай хэрэгжүүлнэ. | 2007-2008 | П.Цагаан |
| | | | 2. Зарим их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад технологи дамжуулах төв байгуулна. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 3. Дулааны хэмнэлттэй орон сууц барих ажлыг дэмжинэ. | 2005-2008 | Н.Батбаяр |
| | | | 4. Барилга, инженерийн шугам сүлжээний шинэ технологи, стандарт нэвтрүүлэх технологийн инкубатор байгуулж ажиллана. | 2005-2008 | Н.Батбаяр |
| | | | 5. Технологи дамжуулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулна. | 2006 | С.Батболд |
| | | | 6. Үйлдвэр технологийн парк байгуулах ажлын хүрээнд эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран технологийн инкубатор байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | С.Батболд |
| **2.4.Үндэсний уламжлалт болон орчин үеийн соёл, урлагийг хөгжүүлэх, хөхиүлэн дэмжих, дэлхийн соёл, урлагаас хүртэх боломжийг иргэддээ чөлөөтэй олгох, олон улсын хэмжээнд Монголын урлаг, соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, соёл, урлагийн орчин үеийн бүтээлийн чанар, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 82 | 2.4.1 | Үндэсний дурсгалт соёлын өв хөрөнгийн талаарх мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр боловсруулан ажиллана. | 1. "Түүх, соёлын дурсгалт зүйлийн бүртгэл -мэдээллийн тоон систем" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ. | 2006-2008 | П.Цагаан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2. Түүх, соёлын дурсгалт зүйлийн мэдээллийг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулна. | 2005-2008 | П.Цагаан |
| 83 | 2.4.2 | Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, өвлөн уламжлах, сурталчлах ажлыг өргөжүүлнэ. | 1. "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | 2005-2006 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 2. Утга соёл, аман өвийн улсын бүртгэл - мэдээллийн сан өргөтгөж, зарим техник, технологийг шинэчлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 3. "Морин хуур, уртын дуу" үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | 2004-2008 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 4. Ардын урлагийн бүтээлийг зохиогчийн эрхээр хамгаалах ажлыг судалж шийдвэрлүүлнэ. | 2007 | Ч. Улаан |
| 84 | 2.4.3 | Музейг мэдээлэл, мэдлэгийн эх сурвалж болгоод зогсохгүй аялал жуулчлал татахад өргөнөөр ашиглахыг дэмжиж музейн сан хөмрөгийг баяжуулах, дохиоллын системд хамруулах ажлыг зохион байгуулна. | 1. Музейг сургалт, эрдэм шинжилгээ, мэдээлэл сурталчилгааны төв болгон үйл ажиллагааг нь өргөжүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 2. Музейг аялал жуулчлалд өргөн ашиглах чиглэл гаргаж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 3. Музейн сан хөмрөгийг баяжуулах, дохиоллын системтэй болгох арга хэмжээ авна. | 2005-2008 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 85 | 2.4.4 | Монголын түүх, урлаг, утга зохиол судлалыг өргөжүүлнэ. | 1. Монголын түүх, театр, кино, цирк, дүрслэх урлаг, яруу найраг, уран зохиол, үгийн зохиол, утга зохиол судлалын чиглэлийг тодорхойлж, холбогдох эрдэмтэн, эрдэм шинжилгээний байгууллагаар судалгааг гүйцэтгүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 2. Дунд, дээд сургуулийн сурах бичиг болон унших материалд түүх, урлаг, утга зохиолын шүүмжийг аль болох олон урсгалч байдлаар зэрэгцүүлэн оруулна. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 3. Судалгааны үр дүнг соёл, урлагийн салбарын бодлого, цаашид хөгжүүлэх үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | П.Цагаан |
| 86 | 2.4.5 | Хөдөөгийн соёл, урлагийн байгууллагуудын барилгыг шинэчлэх, засварлах болон эдгээр байгууллагыг хөгжмийн зэмсэг, техник хэрэгслээр хангах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, үйлчилгээний хүрээг өргөтгөнө. | 1. "Боловсрол, соёлын явуулын иж бүрэн үйлчилгээг Монголын малчдад хүргэх нь" төсөл хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2004-2006 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 2. Аймгийн театр, чуулга, сумдын соёлын төвийг хөгжмийн зэмсгээр хангах арга хэмжээг ээлж дараатай хэрэгжүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Аймаг,нийслэлийн Засаг дарга |
| | | | 3. Орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагын дуу, гэрлийн техникийг шинэчлэх төсөл боловсруулан хэрэгжүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан<br>Н.Алтанхуяг<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 4. Төвийн мэргэжлийн урлаг, соёлын байгууллагаас хөдөөгийн хүн амд үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлнэ. | 2004-2008 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5. Соёл, урлагийн гадаад сурталчилгаар өргөжүүлж, гадаад орон, хандивлагчдын хөрөнгийг татах, гадны хөтөлбөр, төсөлд хамруулах арга хэмжээг өргөтгөнө. | 2005-2008 | П.Цагаан Н.Алтанхуяг Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 6. Соёл, урлагийн байгууллагыг бизнес, аялал жуулчлалын салбартай холбох ажлыг дэмжинэ. | 2005-2008 | П.Цагаан Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 87 | 2.4.6 | Соёл, урлаг, утга зохиолын ажилтан, уран бүтээлчдийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, сургалтад хамруулах, олон улсын наадам, уралдаан, тэмцээнд оролцуулах арга хэмжээг өргөжүүлнэ. | 1. Мэргэжлийн уран бүтээлчдэд мэргэшлийн зэрэг олгох журмыг боловсруулан хэрэгжүүлнэ. | 2005-2007 | П.Цагаан |
| | | | 2. Орон нутгийн соёл, урлагийн байгууллагын уран бүтээлчдэд зориулсан сургалтыг зохион байгуулна. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 3. Өндөр хөгжилтэй оронд соёл, урлагийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх ажлыг өргөжүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 4. Уран бүтээлчдийг олон улсын уралдаан, үзэсгэлэн, номын яармагт оролцуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 5. Соёл, урлаг, утга зохиолын ажилтан, уран бүтээлчдийн дунд оюуны өмчийн хууль тогтоомжийг сурталчлах, сургалт семинар зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | Жил бүр | Ч.Улаан |
| 88 | 2.4.7 | Олон улсын нэр хүндтэй уралдаан, тэмцээнд улсаа төлөөлөн албан ёсоор оролцож, шагнал хүртсэн бүтээлд буюу уран бүтээлчдэд олгодог урамшууллын тогтолцоог боловсронгуй болгоно. | 1. Олон улсын хэмжээнд болдог уралдаан, үзэсгэлэн, номын яармагт улсаа төлөөлөн албан ёсоор оролцож онцгой амжилт гаргасан уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгох тухай журамд өөрчлөлт оруулна. | 2005 | П.Цагаан |
| | | | 2. Оны шилдэг уран бүтээл, уран бүтээлч шалгаруулах журам боловсруулан хэрэгжүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 3. Олон улсын хэмжээний уралдаан, үзэсгэлэн, номын яармагт улсаа төлөөлөн албан ёсоор оролцож амжилт гаргасан уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгох ажлыг зохион байгуулна. | 2005-2008 | П.Цагаан |
| 89 | 2.4.8 | Монголын соёлын өдрүүд, үзэсгэлэнг хэд хэдэн оронд зохион байгуулна | 1. Монголын соёлын өдрүүдийг БНХАУ, БНСУ, АНУ, Австри, Япон, Энэтхэг зэрэг орнуудад зохион байгуулна. | 2005-2008 | П.Цагаан Ц.Мөнх-Оргил |
| | | | 2. ХБНГУ, Австри улсад "Чингис хаан ба түүний өв залгамжлагч" үзэсгэлэн зохион байгуулна. | 2005 | П.Цагаан Ц.Мөнх-Оргил |
| | | | 3. Түрэгийн үеийн түүх, соёлын дурсгалт зүйлийн үзэсгэлэнг Бүгд Найрамдах Турк улсад гаргана. | 2005 | П.Цагаан Ц.Мөнх-Оргил |
| | | | 4. Монголын түүх, соёлын үзэсгэлэнг БНХАУ-д зохион байгуулна. | 2005 | П.Цагаан Ц.Мөнх-Оргил |
| | | | 5. Францад Монгол-Францын археологийн хамтарсан хээрийн олсон зүйлээр үзэсгэлэн гаргана. | 2006 | П.Цагаан, Ц.Мөнх-Оргил |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 90 | 2.4.9 | Монголын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ. | 1. Ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | 2004-2006 | П.Цагаан<br>С.Баярцогт |
| | | | 2. Түүхэн сэдэвт кино, дуурь, ном, хөшөө зэргийг бүтээхэд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. | 2005-2006 | П.Цагаан<br>Н.Алтанхуяг<br>С.Баярцогт |
| | | | 3. Ойд зориулсан төрийн ёслол - хүндэтгэлийн болон соёл, урлагийн арга хэмжээ, онол - практикийн хурал зохион байгуулна. | 2005-2006 | П.Цагаан<br>С.Баярцогт |
| | | | 4. Ойг гадаадад тэмдэглэн өнгөрүүлэх чиглэл боловсруулж, уг арга хэмжээнд Монголыг дэмжигч байгууллага, хүмүүсийг оролцуулна. | 2005-2006 | Ц.Мөнх-Оргил,<br>П.Цагаан, |
| | | | 5. Монголын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойгоор Монгол туургатан хүүхдийн олон улсын их наадам зохион байгуулна. | 2006 | Ч.Улаан<br>П.Цагаан |
| 91 | 2.4.10 | Олимп, дэлхий, тивийн хэмжээнд амжилт гаргах магадлалтай спортын төрлүүдийг тулхүү хөгжүүлнэ. | 1. 2008 оны зуны олимпийн наадамд бэлтгэх асуудлыг боловсруулж шийдвэрлүүлнэ. | 2006-2008 | Т.Ганди |
| 92 | 2.4.11 | Уламжлалт шашны түүх, соёлын судалгааг өргөжүүлнэ. Монгол хэл бичгээ судлах, эүй зохистойгоор эөлөх ажлыг өргөжүүлнэ. Дэлхийн сонгодог болон үндэсний урлаг, хүүхдийн танин мэдэхүй, боловсролыг хөгжүүлэхэд чиглэсэн урлагийг төрөөс дэмжинэ. | 1. Уламжлалт шашин, монгол хэл, соёл судлалын чиглэлийг тогтоож, холбогдох хүрээлэнгүүдээр гүйцэтгүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 2. Бүх шатны сургуулийн монгол хэлний сургалтын чанарыг дээшлүүлнэ. | 2005-2008 | П.Цагаан |
| | | | 3. "Сонгодог урлаг", "Ардын уламжлалт урлагийг дэмжих үндэсний хөтөлбөр", "Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2004-2008 | П.Цагаан |
| | | | 4. Хүүхдэд зориулсан урлаг, уран сайхны шилдэг бүтээл, төрөл бүрийн нийтлэл нэвтрүүлгээр Үндэсний оюуны алтан сан байгуулах, баяжуулах, урамшуулан дэмжих. Эмзэг бүлгийн хүүхдийн гоц авьяас, давуу талыг хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ. | 2006-2008 | П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| **2.5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг улс орон даяар жигд сайжруулж нэр төрлийг нэмэгдүүлэх, иргэд, хамт олны идэвхтэй оролцоонд тулгуурлан хүн амыг эрүүл байлгах, орчин үеийн дэвшилтэт оношлогоо, эмчилгээний аргыг эрчимтэй нэвтрүүлэн эрүүлжүүлэх замаар дундаж наслалтыг уртасгах, хүн амын эрүүл мэндийг сайжруулах, спорт, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ.** | | | | | |
| 93 | 2.5.1 | Эрүүл мэндийн салбарын менежментийг боловсронгуй болгож, улсын болон хувийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, ялангуяа орчин үеийн иж бүрэн оношлогооны төвийг нийслэл хот болон бүсийн төвүүдэд байгуулах санаачилгыг дэмжинэ. | 1. Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | 2006-2008 | Т.Ганди |
| | | | 2. 2005-2015 оны эрүүл мэндийн салбарын хөгжлийн стратеги болох Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Т.Ганди |
| | | | 3. Улаанбаатар хотод орчин үеийн иж бүрэн оношлогооны төв байгуулах төслийг боловсруулж "Мянганы хөгжлийн сорилын сан"-д хамруулах арга хэмжээ авч, Орхон аймгийн нэгдсэн эмнэлгийг бүсийн-оношлогоо эмчилгээний төв болгон бэхжүүлнэ. | 2005-2007 | Т.Ганди |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 4. Уламжлалт анагаах ухааны чиглэлээр ажиллаж байгаа хувийн хэвшлийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний чадавхийг сайжруулан, төрөлжсөн тусламж үзүүлэх оношлогоо, эмчилгээний нэгдсэн төв байгуулах чиглэлийг дэмжинэ. | 2005-2007 | Т.Ганди |
| | | | 5. Бүтээгдэхүүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог төлөвшүүлэх замаар санхүүгийн менежментийг боловсронгуй болгоно. | 2005-2008 | Т.Ганди |
| | | | 6. Клиникийн болон аймаг, сумдын эмнэлгийн лабораторийн чадавхийг нэмэгдүүлнэ. | 2005-2008 | Т.Ганди |
| | | | 7. Алсын зайн оношлогооны (телемедицина) үйл ажиллагаа өргөжүүлнэ. | 2005-2008 | Т.Ганди |
| | | | 8. Төрийн тусгай албан хаагчдын эмчилгээ, сувилгааны нэгдсэн төвийг байгуулан ажиллуулах асуудлыг шийдвэрлэнэ. | 2006-2007 | Ц.Нямдорж |
| 94 | 2.5.2 | Эрүүл мэндийн үйлчилгээнд эрхийн бичгийн системийг нэвтрүүлэх боломжийг судална. | 1. Монгол орны нөхцөлд ялангуяа эмзэг бүлгийн болон 16 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд эрхийн бичиг нэвтрүүлэх боломж болон бусад орнуудад эрхийн бичгийн системийг нэвтрүүлсэн туршлагыг судална. | 2005-2007 | Т.Ганди |
| 95 | 2.5.3 | Эрүүл мэндийн салбарт хөдөлмөрийн үнэлэмж, төлбөртэй уялдсан үйл ажиллагааны стандартыг тогтоон эмч, ажиллагсдын бодит орлогыг нэмэгдүүлнэ. | 1. Хөдөлмөрийн үнэлэмж, төлбөртэй уялдсан үйл ажиллагааны норм, нормчлолын удирдамж боловсруулна. | 2005-2007 | Т.Ганди<br>Ц.Баярсайхан |
| | | | 2. Хөдөлмөрийн үнэлэмж төлбөртэй уялдуулан эмнэлгийн ажиллагсадын орлогыг нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2005-2006 | Т.Ганди<br>Ц.Баярсайхан |
| 96 | 2.5.4 | Клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдийн менежментийг боловсронгуй болгоно. | 1. Клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, төвийн менежментийг сайжруулах төсөл шалгаруулж түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг зарим эмнэлэг дээр туршина. | 2005 | Т.Ганди |
| | | | 2. Клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдэд клиникийн удирдамж, стандарт хэрэглэж хэвшүүлэх арга хэмжээ авна. | 2005-2007 | Т.Ганди |
| | | | 3. Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаар боловсронгуй болгох зорилгоор Улаанбаатар хотын дүүрэг, төвийн эмнэлгүүдийн бүтэц зохион байгуулалтад шинэчлэлт хийнэ. | 2005-2006 | Т.Ганди |
| 97 | 2.5.5 | Эх, нялхсын эрүүл мэндэд онцгой анхаарч, "Мянганы тунхаглал"-д нийцүүлэн эх, нялхсын эндэгдлийг бууруулна. | 1. 2005-2010 онд эхийн эндэгдлийг бууруулах стратеги төлөвлөгөө боловсруулж баталж мөрдүүлнэ. | 2005-2007 | Т.Ганди |
| | | | 2. Сумын эмнэлгийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд нийслэл, аймгийн төвийн эхчүүдийн амрах байрыг тохижуулна. | 2005- 2007 | Т.Ганди |
| | | | 3. "Хүүхдийн өвчний цогц менежмент" хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж хамралтыг өргөжүүлнэ. | 2005-2007 | Т.Ганди |
| | | | 4. Нялхсын хооллолтын үндэсний стратегийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулна. | 2006 | Т.Ганди |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5. "Нөхөн үржихүйн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөрт үнэлгээ хийж Засгийн газарт танилцуулна. | 2006 | Т.Ганди |
| 98 | 2.5.6 | Эрүүл мэндийн даатгалын системийг боловсронгуй болгон бэхжүүлж, хувийн эрүүл мэндийн даатгалыг урамшуулна. | 1. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна. | 2005 | Ц.Баярсайхан Т.Ганди |
| | | | 2. Хувийн эрүүл мэндийн даатгалыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчин бүрдүүлнэ. | 2005-2008 | Ц.Баярсайхан Т.Ганди |
| 99 | 2.5.7 | Эмнэлгийн боловсон хүчин, эмч, сувилагч нарын мэргэшлийг дээшлүүлэхэд анхаарч, орчин үеийн тоног төхөөрөмжийг эзэмшүүлэх, олон улсын шаардлага хангахуйц мэргэшсэн сувилагчдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээг авна. | 1. Сумын эмч, өрхийн эмч нарыг давтан сургалтанд хамруулах асуудлыг одоогийн түвшинээс 10 хувиар нэмэгдүүлнэ. | 2005- 2008 | Т.Ганди |
| | | | 2. Анагаахын мэргэжилтэн бэлтгэх тогтолцоонд мэргэжлийн холбоодын оролцоог хангах эрх зүйн орчин бүрдүүлэх замаар олон улсын шаардлага хангахуйц мэргэшсэн сувилагчдын тоог нэмэгдүүлнэ. | 2005-2008 | Т.Ганди П.Цагаан |
| 100 | 2.5.8 | Иргэд хүрээлэн буй орчин, эрүүл ахуйн талаарх мэдээллээ чөлөөтэй олж авах, эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, биобэлдмэлийг зөв хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ. Дээрх мэдээллийг өөрсдийн эрүүл мэндтэйгээ холбон ойлгох, эрүүл ахуйн шаардлагаа хангуулахын төлөө холбогдох этгээдэд зүй ёсны шаардлага тавих чиглэлээр иргэдэд мэргэжлийн туслалцаа үзүүлж буй иргэний нийгмийн санаачилгыг дэмжинэ. | 1. Хүн амд эрүүл мэндийн боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаар өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2005- 2008 | Т.Ганди П.Цагаан |
| | | | 2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, радио, телевизүүдээр эрүүл мэндийн сургалт сурталчилгааны төлөвлөгөөт нэвтрүүлэг дамжуулах ажлыг зохион байгуулна. | 2005-2008 | Т.Ганди |
| | | | 3. Орчны эрүүл мэндийг сайжруулах үндэсний хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | 2005- 2008 | Т.Ганди У.Барсболд |
| | | | 4. Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн чиглэлээр олон нийтэд зориулсан хэвлэл мэдээллийн сурталчилгааг өргөжүүлж, вэб-хуудастай болох ажлыг зохион байгуулна. | 2006 | Т.Ганди Д.Тэрбишдагва |
| | | | 5. Эм, химийн хордлогын мэдээллийн төвийг бэхжүүлэн хүн амд хүргэх эмийн мэдээллийг сайжруулж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллага холбогдох мэдээлэл авах боломжийг бүрдүүлнэ. | 2006 | Т.Ганди |
| 101 | 2.5.9 | Хүнсний болон эмийн аюулгүй байдлыг хангах зорилгоор зохих стандартуудыг шинэчлэн тогтоож, үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, импортын нарийвчилсан бодлого хэрэгжүүлнэ. | 1. Эмийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Эмийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна. | 2006 | Т.Ганди |
| | | | 2. Монгол Улсад хэрэглэж байгаа эмийн чанарын баталгаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор үндэсний фармакопейг боловсруулна. | 2005- 2008 | Т.Ганди Д.Тэрбишдагва |
| | | | 3 Эм хангамж, эмийн үйлдвэр, эмийн сангийн стандартыг боловсруулж мөрдөнө. | 2005 | Т.Ганди |
| | | | 4. Хүнс, эмийн аюулгүй байдлын стандартыг шинэчлэн тогтооно. | 2007 | Т.Ганди Д.Тэрбишдагва |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5. Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг сайжруулах, малын эмийн хэрэглээ, хангамжийг зохистой байлгах зорилгоор Хүнсний тухай болон Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 6. Малын шимэгчидтэй тэмцэхэд хэрэглэх эмийн бэлтгэн нийлүүлэлтийг төреөс санхүүжүүлдэг зарчмыг өөрчилж, эпидемилогийн судалгаа, лабораторийн шинжилгээ, эрүүлжүүлэх хөтөлбөрийг санхүүжүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулна. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 7. Мал эмнэлэгт хэрэглэж байгаа антибиотик, пестицид эмийн бодисын талаарх бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгож олон улсын шаардлагын түвшинд ойртуулна. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 8. Хүнсний бүтээгдэхүүнд малын эм, антибиотик пестицидийн үлдэгдэл тодорхойлох чадавхи бий болгоно. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 9. Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг стандартчилна. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 10. Малын эмийн үйлдвэрлэлд тавигдах ерөнхий нөхцөлийн стандартыг боловсруулж батлуулж мөрдүүлнэ. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 11. Олон улсын хүнсний эрх зүйн комиссоос баталсан зөвлөмж стандартуудад хүнсний үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариун цэврийн талаарх үндэсний стандартыг нийцүүлэх боломжийг судалж шийдвэрлэнэ. | 2005 | Д.Тэрбишдагва |
| 102 | 2.5.10 | Эрүүл мэндийн үйлчилгээний чирэгдлийг багасгах, ачааллыг жигд хуваарилах, яаралтай тусламжийг цаг алдалгүй үзүүлэн, эндэгдлийг багасгахад чиглэсэн эмнэлэг дундын мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулна. | 1. Эмнэлэг дундын мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах асуудлыг үе шаттайгаар зохион байгуулж, нэг цэгийн үйлчилгээг шуурхай болгоно. | 2005-2007 | Т.Ганди |
| | | | 2. Клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдийн консорциумыг байгуулах ажлыг дэмжиж түүгээр дамжуулан эмнэлэг, үйлчилгээний чирэгдлийг бууруулан ажлын уялдаа холбоог сайжруулна. | 2005-2007 | Т.Ганди |
| | | | 3. Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцооны стратеги-төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Т.Ганди |
| 103 | 2.5.11 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэн шаардлагатай багц, нэмэлт багцыг тусламж үйлчилгээний шатлал бүрд хэрэгжүүлж хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг хангана. | 1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэн шаардлагатай багц, нэмэлт багцыг тодорхойлж сумдын эмнэлэгт 2006 оны I хагас жил, аймгуудын нэгдсэн эмнэлэгт 2007 оны I хагас жил, клиникийн эмнэлгүүд болон нарийн мэргэжлийн төвүүдэд 2007 оны II хагас жилд тус тус хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | 2006-2007 | Т.Ганди |
| | | | 2. Эмчилгээ оношлогооны тоног төхөөрөмжийн чанарын баталгаажилтын лавлагаа лаборатори байгуулна. | 2004-2008 | И.Эрдэнэбаатар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 104 | 2.5.12 | Олон улсын хөл хориот өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүн амыг хамгаалахад чиглэсэн явуулын лаборатори, оношлогоо, эмчилгээний багуудын чадавхийг сайжруулна. | 1. Холбогдох байгууллагуудтай хамтран олон улсын хөл хориот өвчний чиглэлээр шаардагдах оношлуур, тоног төхөөрөмжөөр явуулын лабораториудыг хангах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна. | 2005-2008 | Т.Ганди |
| | | | 2. Олон улсын хөл хориот өвчний үед ажилладаг явуулын багуудын эмч мэргэжилтний сургалтад хамруулах замаар чадавхийг нь сайжруулах арга хэмжээ авна. | 2005- 2008 | Т.Ганди |
| 105 | 2.5.13 | Халдварт өвчнийг эсэргүүцэх эм тарилга, вакцины нөөцийг зохих түвшинд бүрдүүлж, хүн амд тараах хамгаалалтын тусгай хэрэгслийн хангалтыг хийнэ. Дархлаажуулалтанд хавсарсан вакцин нэвтрүүлэх замаар эрүүл хүүхдэд хийх тарилгын тоог цөөрүүлнэ. | 1. Халдварт өвчнийг эсэргүүцэх эм тарилга, вакцины жил бүр 20 хувийн нөөцтэй байхаар тооцож, төсвийн болон олон улсын байгууллагуудын санхүүжилтээр хангах арга хэмжээ авна. | 2005-2008 | Т.Ганди |
| | | | 2. Олон улсын хөл хориот өвчний үед хүн амд тараах хамгаалалтын тусгай хэрэгслийн нөөцтэй болох ажлыг зохион байгуулна. | 2005- 2008 | Т.Ганди |
| | | | 3. Дархлаажуулалтад тавт вакциныг шинээр нэвтрүүлж эрүүл хүүхдэд хийх тарилгын хатгалтыг цөөрүүлж дархлаажуулалт бүхий халдварт өвчний гаралтыг эрс бууруулна. | 2005- 2008 | Т.Ганди |
| 106 | 2.5.14 | Зүрх судасны өвчин, хорт хавдар, осолоос шалтгаалсан нас баралтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. | 1. "Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хяналт тавих нэгдсэн хөтөлбөр"-ийг боловсруулна. | 2005 | Т.Ганди |
| | | | 2. Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-д өргөн мэдүүлнэ. | 2005 | Т.Ганди |
| | | | 3. "Хорт хавдартай тэмцэх", "Осол гэмтлээс сэргийлэх" үндэсний хөтөлбөрүүдэд үр дүнгийн үнэлгээ хийнэ. | 2008 | Т.Ганди |
| 107 | 2.5.15 | Түргэн тусламжийн үйлчилгээний шуурхай байдал нь оршин суугчдын шилжилт хөдөлгөөн, байршлаас хамаарахгүйгээр тогтоосон стандартын хэмжээнд байхаар тооцож, хот байгууллалтыг төлөвлөж хэрэгжүүлнэ. | 1. Хот, хөдөөд түргэн тусламжийн машины парк шинэчлэл болон нөхөн хангалтыг дэс дараатайгаар хийнэ. | 2005-2008 | Т.Ганди |
| | | | 2. Түргэн тусламжийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах зорилгоор Түргэн тусламжийн төвийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгоно. | 2005 | Т.Ганди |
| | | | 3. Нийслэлд яаралтай тусламжийн төв байгуулах асуудлыг судална. | 2006 | Т.Ганди |
| | | | 4. Хот төлөвлөлтийн шинэчилсэн норм, норматив боловсруулахад түргэн тусламжийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах стандартыг тогтоож өгнө. | 2005-2008 | Н.Батбаяр Нийслэлийн Засаг дарга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 108 | 2.5.16 | Эрүүл аж төрөхөд чухал шаардлагатай явган хүний гүйлтийн болон унадаг дугуйн зам, нээлттэй орон зай, талбай, ногоон зам, тусгаж байх явдлыг хот бүсийг төлөвлөлтийн зайлшгүй элемент болгож, үг талбайд шаардагдах газрыг өөр зориулалтаар ашиглуулахаар олгохыг хязгаарлана. | 1. Явган хүний гүйлтийн болон унадаг дугуйн зам, талбай, ногоон бүсийг тухайн хотын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний төсөлд тусгаж байхаар холбогдох дүрэм журамд оруулж, хяналт тавьж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Н.Батбаяр И.Эрдэнэбаатар Нийслэлийн Засаг дарга |
| 109 | 2.5.17. | Баг, сумын болон өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний чадавхийг сайжруулах ажлыг дэс дараатай авч хэрэгжүүлж эхэлнэ. | 1. Эмчилгээ оношлогооны чадавхийг сайжруулах зорилгоор баг, сумын эмч нарын бүсчилсэн сургалт, семинар зохион байгуулж гарын авлагаар хангана. | 2005-2008 | Т.Ганди |
| | | | 2. Өрхийн эмнэлгийн багаж, хэрэгслийн хангалт ашиглалтыг стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулж оношлогооны чадавхийг нэмэгдүүлнэ. | 2005-2008 | Т.Ганди |
| | | | 3. Зориулалтын бус байртай сумын эмнэлэгт шинээр байр барих ажлыг үргэлжлүүлж сумдын эмнэлгийн барилгын 60-аас доошгүй хувьд их болон урсгал засварыг хийж гүйцэтгэнэ. | 2005-2008 | Т.Ганди |
| | | | 4. Олон улсын байгууллагатай хамтран олон улсын жишигт нийцсэн 3-5 сумын эмнэлгийг байгуулж туршилтын журмаар ажиллуулна. | 2005-2008 | Т.Ганди Н.Алтанхуяг |
| 110 | 2.5.18 | Хүн амд эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажлыг бүх талаар дэмжиж, бүсийн тэвүүдэд спортын цогцолбор барьж, үндэсний бөх, морь, сурын спортыг уламжлал шинэчлэлийг хослуулах үндсэн дээр хөгжүүлж, нийслэлд олимпийн цогцолбор байгуулах санаачилгыг дэмжинэ. | 1. Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | 2006- 2008 | Т.Ганди |
| | | | 2. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажлыг бүх талаар дэмжин мэргэжилтнүүдийн сургалт зохион байгуулж, тэднийг мэргэшүүлэх, дахин сургахад анхаарна. | 2005- 2008 | Т.Ганди П.Цагаан |
| | | | 3. Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Оюутны, Хүүхдийн, Үндэсний спортын их наадмууд болон бүх ард түмний спартакиадыг зохион байгуулна. | 2005-2008 | Т.Ганди |
| | | | 4. Бүсүүдэд спортын төвүүдийг барьж, нийслэлд спорт цогцолбор байгуулах санаачилгыг дэмжинэ. | 2005-2008 | Т.Ганди |
| **2.6 Нийгмийн даатгалын төрөл, сонголтыг нэмэгдүүлэх, нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдах баталгааг сайжруулах, эмзэг хэсэгт үзүүлэх халамж, үйлчилгээг чанартай хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурал, ажилгүйдлийг багасгах зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 111 | 2.6.1 | Ажил олгогчид ногдох татвар, шимтгэлийн ачааллыг бууруулж, хөдөлмөрийн багтаамж ихтэй үйлдвэрлэлийг дэмжих замаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | 1. Тэтгэврийн даатгалын санд ажил олгогчийн төлөх шимтгэлийг бууруулах замаар ажил олгогч, даатгуулагчийн тэтгэврийн даатгалд төлөх шимтгэлийн зохистой харьцааг тогтоох эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2006 оноос | Ц.Баярсайхан |
| | | | 2. Ядуу айл өрхийн ажилгүй гишүүдийг боломжтойгоор хөдөлмөрийн багтаамж ихтэй ажилд татан оролцуулах арга хэмжээ авна. | 2005 оноос | Ц.Баярсайхан |
| | | | 3. Нийтийг хамарсан ажлыг байгаль орчныг хамгаалах болон нөхөн сэргээх, зам барих, цөлжилттэй тэмцэх зэрэг хөдөлмөрийн багтаамж ихтэй үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт түлхүү зохион байгуулах чиглэл баримтална. | 2005 оноос | Ц.Баярсайхан Н.Батбаяр У.Барсболд Г.Батхүү |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 112 | 2.6.2 | Хүүхдэд төрсөн цагаас нь иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын дугаар олгоно. | 1. Иргэн бүр оршин суугаа харъяаллаасаа үл хамааран нийгмийн хамгааллын үйлчилгээ хүртэх боломжийг бүрдүүлэх чиглэлээр бусад орны туршлагыг судалж, хүүхдэд төрсөн цагаас нь нийгмийн хамгааллын дугаар олгох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлэнэ. | 2006 оноос | Ц.Баярсайхан |
| | | | 2. Хүүхдэд төрсөн цагаас нь иргэний үнэмлэх олгох асуудлыг судлан санал боловсруулна. | 2005-2006 | Ц.Намдорж<br>Ц.Баярсайхан |
| 113 | 2.6.3 | Тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын одоогийн тогтолцоог боловсронгуй болгохын зэрэгцээ хувийн нэмэгдэл даатгалын тогтолцоо бий болгох, нийгмийн даатгалд гэр бүлийн хүлээх сайн дурын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар хамрах хүрээг өргөжүүлж иргэдийн нийгмийн баталгааг сайжруулах арга хэмжээ авна. | 1. Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэврийн зэрэгцээ ажил олгогчдоос санхүүжүүлэх нэмэгдэл тэтгэврийн болон хувийн өндөр насны тэтгэврийн хуримтлалын хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2006 | Ц.Баярсайхан<br>Т.Ганди |
| | | | 2. Жирэмсэн, амаржсаны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж даатгуулагчийн авч байсан цалин, орлогын 100 хувьд хүргэх арга хэмжээ авна. | 2005 | Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг |
| | | | 3. Тавааас доош жил шимтгэл төлж ажилласан даатгуулагчид олгох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг авч байсан цалин, орлогын 50 хувьд хүргэж нэмэгдүүлэн хуанлийн 6 сар хүртэл хугацаанд ногдох ажлын өдрөөр тооцож олгодог болно. | 2005 | Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг |
| 114 | 2.6.4 | Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, тариаланчдын эрх ашгийг дэмжиж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг судалж, эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 1. Малчид, албан бус секторт хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2006-2007 | Ц.Баярсайхан |
| | | | 2. Малчид, албан бус секторт хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын хөтөлбөр боловсруулж сонгосон аймаг дүүрэгт туршина. | 2005 | Ц.Баярсайхан |
| 115 | 2.6.5 | Нийгмийн даатгалын сангийн бие даасан байдлыг баталгаажуулж, уг санг эрсдэлээс хамгаалах бодлогыг хэрэгжүүлнэ. | 1. Тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг багасгах, хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоонд шилжих үеийн эрсдлийг бууруулахад чиглэсэн багц арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2006-2008 | Ц.Баярсайхан |
| | | | 2. Төрийн сангаас нийгмийн даатгалын сангуудын хөрөнгийн үлдэгдэлд төлөх хүүгийн хэмжээг зах зээлийн хүүгийн жишигт нийцүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авна. | 2005 оноос | Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг |
| 116 | 2.6.6 | 1995 оноос өмнө ба хойно тогтоосон тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг арилгах арга хэмжээг дэс дараатай авна. | 1. Тэтгэврийн зөрүү арилгах арга хэмжээнд хамрагдах хүмүүсийн тооцоог гаргах, итгэлцүүр хэрэглэх арга замын талаар санал боловсруулна. | 2005 | Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг |
| | | | 2. 1995 оноос өмнө болон хойно тогтоосон тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг арилгах талаар судалгаа, тооцоо хийж шаардагдах хөрөнгийг тухайн жилийн улсын төсөвт тусгаж, үе шаттайгаар арилгах арга хэмжээ авна. | 2005-2008 | Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 117 | 2.6.7 | Аймгийн болон бүсийн төвүүдэд ахмад настанд зориулсан нөхөн сэргээх, асран сувилах газруудыг байгуулж, тэдгээрийг дэмжиж ажиллана. | 1. Геронтологи сэргээн засалтын төвийн үйл ажиллагааг бие даасан статустайгаар ажиллуулна. | 2005 оноос | Ц.Баярсайхан |
| | | | 2. Аймгийн болон бүсийн төвүүдэд гериатрийн зөвлөлгөө өгөх төв, тасаг, кабинетийн үйл ажиллагааг дэмжиж, өргөтгөх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | 2005-2008 | Ц.Баярсайхан |
| 118 | 2.6.8 | Ахмад настнуудын нийгмийн хамгааллыг сайжруулахын зорилгоор тэдэнд зориулсан үйлчилгээ үзүүлэх, ахмадуудыг нийгмийн амьдралд идэвхтэй оруулах арга хэмжээг зохион байгуулж буй аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын нийгмийн санаачилгыг дэмжинэ. | 1. Ахмад настан болон нийгмийн эмзэг бүлгийнхэнд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээний нэр төрөл, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх болон тогтолцоог бүрдүүлэх загвар туршилтын төслүүдийг сонгосон аймаг дүүргүүдэд туршин нэвтрүүлнэ. | 2005 | Ц.Баярсайхан |
| | | | 2. Ахмад настанд нийгэм, хамт олонд тулгуурласан хэлбэрээр хүргэх асран халамжлах үйлчилгээг Төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ. | 2005-2008 | Ц.Баярсайхан |
| | | | 3. Нийгмийн хамгааллын хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр туршилтын төсөл хэрэгжүүлнэ. | 2005 оноос | Ц.Баярсайхан |
| 119 | 2.6.9 | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, төрийн албан хаагчдын болон төсөвт байгууллагад ажиллагсдын үндсэн цалингийн хэмжээг эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшин, төсөвт байгууллагын зардлын хэмнэлттэй уялдуулан нэмэгдүүлэх бодлого баримтална. | 1. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээ, төрийн албан хаагчид болон төсөвт байгууллагад ажиллагчдын үндсэн цалингийн хэмжээг эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшинтэй уялдуулан индексжүүлэн нэмэгдүүлнэ. | Жил бүр | Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг |
| 120 | 2.6.10 | Нийгмийн хамгааллын үйлчилгээг нийгэм, хамт олонд түшиглэсэн хэлбэрээр хөнгөн шуурхай, уян хатан хүргэх үүрэг бүхий нийгмийн үйлчилгээний төвийг бүсийн төвүүд болон нийслэлийн зарим дүүрэгт туршин ажиллуулна. | 1. АХБ-ны техник туслалцааны дэмжлэгтэйгээр Өвөрхангай аймгийн Арвайхээр хот болон нийслэлийн Баянгол дүүрэгт нийгмийн үйлчилгээний загвар төвийг туршин ажиллуулна. | 2005 оноос | Ц.Баярсайхан |
| | | | 2. Нийгмийн халамж , хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нэг цэгээс иргэдэд хүргэх нийгмийн үйлчилгээний төвийг бүсийн төвүүдэд байгуулж ажиллуулна. | 2006-2008 | Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг |
| | | | 3. Төвөөс алслагдсан айл өрх, иргэд, хүүхдэд "Нийгмийн суурь" үйлчилгээг цогцоор хүргэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг олон улсын болон гадаадын түншлэгч байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | 2005-2008 | Ц. Баярсайхан<br>Н.Алтанхуяг |
| | | | 4. Нийгмийн халамжийн тогтолцоонд өөрчлөлт хийх асуудлыг судлан шийдвэрлэж, нийгэм, хамт олонд түшиглэсэн халамж, үйлчилгээний шинэ хэлбэрийг турших замаар нийгмийн халамжид хамрагдах шалгуур үзүүлэлт, өрх, иргэдийн амьжиргааг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгоно. | 2005 | Ц.Баярсайхан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5. Нийгмийн хамгааллын үйлчилгээг нийгэм, хамт олонд түшиглэсэн хэлбэрээр хөнгөн шуурхай, уян хатан хүргэх нийгмийн үйлчилгээг бусийн төвүүд болон нийслэлийн зарим дүүрэгт үзүүлэх талаар судалгаа хийж, туршин ажиллуулна, түүнийг орон нутагт хэрэгжүүлнэ. | 2006-2008 | Ц.Баярсайхан |
| 121 | 2.6.11 | Ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг харилцан зөвшөөрөх, магадлан итгэмжлэх, үнэмлэхжүүлэх болон ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, хөдөлмөрлөх эрхийг харилцан зөвшөөрөх гэрээ, хэлэлцээрийг сонирхсон орнуудтай байгуулж хэрэгжүүлнэ. | 1. Ази-Номхон далайн орнуудын магадлан итгэмжилж батламжлах комисст гишүүнээр элсч, ажилчдын мэргэжлийн ур чадварыг харилцан хүлээн зөвшөөрөх, ажиллах хүчний шилжих хөдөлгөөн, хөдөлмөрлөх эрхийг харилцан зөвшөөрөх асуудлаар Азид идэвхитэй үйл ажиллагаа явуулна. | 2004-2008 | Ц.Баярсайхан<br>П.Цагаан<br>Ц.Мөнх-Оргил |
| | | | 2. Ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөн, хөдөлмөрлөх эрхийг харилцан зөвшөөрөх сонирхол бүхий орнуудын саналыг нарийвчлан судалсны үндсэн дээр гэрээ, хэлэлцээр байгуулна. | 2005 оноос | Ц.Баярсайхан<br>Ц.Мөнх-Оргил |
| 122 | 2.6.12 | Эдийн засгийн тогтвортой байдлыг макро түвшинд хангаж, өсөлтийг дэмжих, бизнесийн таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах замаар 145 мянгаас доошгүй ажлын байр шинээр бий болгоно. | 1. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх замаар жил бүр 37000-аас доошгүй ажлын байр бий болгоход Засгийн газрын зүгээс дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Жил бүр | Ц.Баярсайхан<br>Сайд нар |
| | | | 2. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг сайжруулж жилд 25000-аас доошгүй хүнийг ажилд зуучилна. | Жил бүр | Ц.Баярсайхан |
| | | | 3. Ховор мэргэжлийн ажилчид бэлтгэх, ажилчдын мэргэжлийн ур чадварыг сайжруулах үндсэн дээр гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрт ажиллаж байгаа монгол ажилчдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Ц.Баярсайхан |
| | | | 4. "Дөчин мянган орон сууц хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх замаар ажлын байрыг шинээр бий болгоно. | 2005-2008 | Н.Батбаяр<br>Ц.Баярсайхан |
| | | | 5. Жижиг, дунд үйлдвэр, жижиг бизнесийг өргөтгөх, санхүү, зээлийн механизм бий болгох замаар үйлдвэр, худалдаа, уул уурхайн салбарт ажлын байр нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2005-2008 | С.Батболд |
| 123 | 2.6.13 | Ажиллах хүчний бүтээмж, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарна. | 1. Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр, төслийн хүрээнд эхэлсэн мэргэжлийн болон аж ахуй эрхлэх ур чадварын сургалтын тогтолцоог бүрдүүлэх асуудлыг шийдвэрлэж, мэргэжлийн боловсрол сургалтын 6 бүсийн төв, хөдөлмөр эрхлэлт сургалтын 25, хөдөлмөр эрхлэлт боловсролын 40 төв байгуулж, эрэлтэд тулгуурласан "Эрхийн бичиг"-ийн сургалтын системийг өргөжүүлэн жилд 12000-аас доошгүй хүнийг мэргэжлийн болон ур чадварын сургалтад хамруулна. | 2005-2008 | Ц.Баярсайхан |
| | | | 2. Ажилтны мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд чиглэгдсэн мэргэжлийн ур чадварын шалгалт зохион байгуулах, мэргэжлийн гэрчилгээ олгох тогтолцоо бүрдүүлнэ. | 2005-2008 | Ц.Баярсайхан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3. Ажилчдын бүтээмж нэмэгдүүлэх хөдөлгөөн, ажил дээрх сургалт зохион байгуулах арга зүйг боловсруулж, сонгосон аж ахуйн нэгж байгууллагад нэвтрүүлнэ.<br><br>4. Эрэлтэд тулгуурласан "Эрхийн бичиг"-ийн сургалтын системийг өргөжүүлж төвлөрсөн хот, орон нутагт нэвтрүүлнэ. | 2004-2008<br><br>2005 оноос | Ц.Баярсайхан<br><br>Ц.Баярсайхан |
| 124 | 2.6.14 | Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх хөдөлмөрийн бирж, мэдээллийн төвүүдийг багтаан орчин үеийн мэдээлэл, харилцааны технологи бүхий мэдээллийн сүлжээ байгуулна. | 1. Ажил зуучлал, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн үйлчилгээ явуулж байгаа төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин, мэдээлэл солилцоог сайжруулах, тэдгээрийг хамруулсан мэдээллийн сүлжээ, вэб хуудастай болох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлүүлнэ. | 2005-2008 | Ц.Баярсайхан<br>С.Баярцогт |
| 125 | 2.6.15 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг гаргах эрх зүйн зохицуулалттай бий болгоно. | 1. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын тухай хуульд ажил олгогч болон ажилчдад зориулсан сургалт сурталчилгаа, мэдээлэл зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд уг сангаас хөрөнгө зарцуулах талаар нэмэлт, өөрчлөлт оруулж УИХ-д өргөн мэдүүлнэ. | 2005 | Ц.Баярсайхан<br>Ц.Нямдорж |
| 126 | 2.6.16 | Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийг нэвтрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг ажил олгогчид болон ажиллагчдын идэвхтэй оролцоотойгоор хэрэгжүүлнэ. | 1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн систем нэвтрүүлэх мастер төлөвлөгөө боловсруулна.<br><br>2. Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн систем нэвтрүүлэх удирдамж, түүний загвар боловсруулан сонгосон аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрүүлэх, турших арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2005<br><br>2005 оноос | Ц.Баярсайхан<br><br>Ц.Баярсайхан |
| 127 | 2.6.17 | Гадаадад хөдөлмөр эрхлэгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоно. Тэдэнд төрөөс үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлж зуучлах үйлчилгээнд төрийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ. | 1. Гадаад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг чиг хандлага, олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлэн гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.<br><br>2. Гадаад хөдөлмөр эрхлэлтийн менежментийн чадавхийг сайжруулах асуудлаар Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагатай идэвхтэй хамтран ажиллаж техникийн туслалцаа авна. | 2005<br><br>2004-2008 | Ц.Баярсайхан<br>Ц.Мөнх-Оргил<br><br>Ц.Баярсайхан<br>Ц.Мөнх-Оргил |
| 128 | 2.6.18 | Ажиллагсдад эрхээ хамгаалуулахад дэмжлэг үзүүлж, хөдөлмөрийнхөө үр шимийг шударга хүртэх боломжийг нэмэгдүүлнэ. Үйлдвэрчний эвлэлийн болон ажил олгогч эздийн байгууллагатай хамтран нийгмийн түншлэлийн харилцааг хөгжүүлнэ. | 1. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас дэвшүүлэн тавьсан "Зохистой хөдөлмөрийн төлөө" үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөг Засгийн газар, ажил олгогчид болон хөдөлмөрчдийн төлөөллийн байгууллагууд хамтран хэрэгжүүлнэ.<br><br>2. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагатай хамтран "Нийгмийн түншлэлийг дэмжих" төслийн хүрээнд нийгмийн түншлэлийн харилцааг орон нутагт хөгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авна.<br><br>3. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрүүдийг байгуулж хэрэгжүүлнэ. | 2005<br><br>2005-2008<br><br>2005-2008 | Ц. Баярсайхан<br><br>Ц.Баярсайхан<br><br>Ц. Баярсайхан |

(Үргэлжлэл нь дараагийн дугаарт)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар- 12.
Төрийн ордон
☎ 329612 Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329187
Хэвлэлийн хуудас 5